

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-34
<hr/>	
1. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	5-7
2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	7-9
3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт	9-28
4. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай/	29-33
5. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	33-34

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
05 дугаар сарын 26-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 26 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Д.Батбаяр, С.Лүндэг, Р.Сэддорж, Ц.Туваан, А.Ундраа;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Батцэцэг, С.Ганбаатар, Х.Ганхуяг, Б.Уянга.

Нэг. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл нар байлцав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай хариулж, тайлбар хийв.

Б.Бейсен: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Э.Сугарбаяр, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл нар байлцав.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Л.Мөнхбаясгалан, П.Батчимэг, М.Ганхүлэг, Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Н.Алтаншагай, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцав.

Уг асуудлыг 17 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, С.Замира, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Б.Бейсен: “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 17 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, С.Замира нар үг хэлэв.

Б.Бейсен: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 57 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 26 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 51,7 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй /БОХХАА/-н байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүн сонгогдсон тойрог, нэрээр танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн ирсэн байна, Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна, Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна, Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна, Очирбатын Амгаланбаатар гишүүн ирсэн байна, Буланы Бейсен гишүүн ирсэн байна, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна, Сонгобайн Замира гишүүн ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал танилцуулъя. Хэлэлцэх асуудал 4 асуудал хэлэлцэнэ. 1 дүгээрт, Улсын Их Хурлын тогтоолын төсөл Монгол Улсын Засгийн газар /ЗГ/-т чиглэл өгөх тухай. 2-т Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсэг байгуулах тухай. 3-д Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал дүгнэлттэй танилцах. 4-д Байнгын хорооны тогтоолын төсөл Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай. 5 дугаарт Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсэг байгуулах тухай. Ийм 5 асуудал байна.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд байхгүй байна. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байхгүй байгаа тул хэлэлцэх асуудлыг баталлаа. Хэлэлцэх асуудалд орёе.

Нэг. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

БОХХАА байнгын хорооны 2025 оны 18 дугаар тогтоолоор байгуулагдсан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 5-ны өдөр сонссон. Ажлын хэсгээс ЗГ-т чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байгаа. Энэ

санал, дүгнэлтийг боловсруулсан Мөнхсоёл гишүүний төрсөн өдөр юм байна. Танд баярын мэнд хүргэе төрсөн өдрийн.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Ш.Батбаяр Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/-ын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч, ажлын хэсгийг оруулъя. Г.Энхмөнх, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны үнэлгээний газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /НЗДТГ/-аас Ө.Ганболд НЗД-ын Хот, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан зөвлөх, энэ Засаг дарга, хотын Засаг дарга солигдож байгаатай холбоотой ирээгүй байна. Мөн М.Үнэнбат НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга ийм асуудалтай холбоотой ирээгүй байна. Б.Дэлгэрбаяр зөвлөх нь ирсэн байна.

Тогтоолын төслийн танилцуулгыг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл танилцуулна. Мөнхсоёл гишүүний микрофон өгье. Мөнхсоёл гишүүний микрофон өгье. Ороогүй юм уу та? Мөнхсоёл гишүүний микрофон өгье.

Б.Мөнхсоёл: Хог хаягдлын эрх зүйн орчныг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийн танилцуулга. Монгол Улсын Их Хурлын БОХХАА-н байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 18 дугаар тогтоолоор батлагдсан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаад, санал, дүгнэлтээ сая та бүхэнд танилцуулсан. Монгол Улсын хог хаягдлын менежмент санхүүжилтийн тогтолцоо нь зөвхөн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлахад төвлөрсөн, хүний нөөц тогтворгүй, хариуцлагын механизм сул байгаа нь салбарын хөгжлийг хязгаарлаж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нэмэгдүүлж байна.

Нэн тэргүүнд хог хаягдлын санхүүжилтийн тогтолцоог шинэчилж, үүсгэсэн хэмжээгээр төлөх зарчимд суурилсан төлбөрийн механизмыг бүрдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага /ААНБ/-ын хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүрэг тогтоож байгаа эрх зүйн өнөөгийн орчныг өөрчлөн чөлөөт үнийн тогтолцоонд шилжүүлэх нь зүйтэй байна. Ингэснээр үйлчилгээний чанар, үр ашиг дээшилж, хог хаягдал бууруулах эдийн засгийн хөшүүрэг бодитоор бий болно. Үйлдвэрлэгч импортлогчийн өргөтгөсөн хариуцлагын тогтолцоог бүрэн хэрэгжүүлж, ялангуяа цахим цахилгаан хэрэгсэл, сав, баглаа боодол зэрэг бүтээгдэхүүний хаягдлыг эргүүлэн татах, дахин боловсруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Үүнтэй уялдуулан депозит систем, урамшууллын механизмыг нэвтрүүлэх нь чухал юм.

Орон нутгийн түвшинд хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийн менежмент сул, хэмжилт, бүртгэлийн тогтолцоо хангалтгүй байгаа тул авто пүү хэмжилтийн техник хэрэгслээр бүрэн хангаж, нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийг хөгжүүлэх шаардлагатай байна. Мөн төвлөрсөн цэгүүдийг байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн иж бүрэн судалгаанд үндэслэн шинэчлэх, нөхөн сэргээх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх нь зүйтэй. Энэхүү цогц арга хэмжээний саналуудыг үе шаттай хэрэгжүүлснээр нийслэл, хот, орон нутгийн хэмжээнд хог хаягдлын менежментэд оролцогч талуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлэн, хог хаягдал үүсгэж байгаа хэмжээгээр төлөх төлбөрийн шударга системд шилжиж, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн

ашиглах үйлдвэрүүдийг татвар, урамшууллын бодлогоор дэмжин, үйлдвэрлэгч импортлогчийн өргөтгөсөн хариуцлагын тогтолцоог бүрдүүлж чадна гэж үзэж байна.

Иймд ажлын хэсгээс дээрх асуудлыг тусган хог хаягдлын менежментийн санхүүгийн тогтолцоог шинэчлэх, хог хаягдлыг эх үүсвэр дээр багасгах, ангилан ялгах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Хог хаягдлын эрх зүйн орчныг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг боловсрууллаа. Ажлын хэсгээс бэлтгэсэн тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Бейсен: Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн байхгүй байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. Тогтоолын төсөл та бүхэнд хүргүүлсэн байгаа, уншиж танилцуулах уу? Тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураана. Санал хураалтад бэлдээрэй гишүүд. Санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт. Одонтуяа гишүүнийг дэмжсэнээр аваарай. Тогтоол 52,9 хувиар дэмжигдлээ. Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл танилцуулна. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

15.35 цаг

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Дараагийн асуудалд оръё. Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их, Мөнхсоёл гишүүн санал хураалттай байгаа шүү та. Тийм билүү? Монгол Улсын Их Хурлын гишүүн Мандхай нарын 33 гишүүнээс 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр /ХХААХҮ/-ийн салбарт 2008 оноос хойших хугацаанд төрөөс олгож байгаа дэмжлэг, урамшуулал, ЗГ-аас хариуцан төлж байгаа зээлийн хүүгийн татаас олголтын байдал, хэрэгжилт сэдвээр ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлт ирүүлснийг Байнгын хороо хүлээн авч, сонсголын тов болон сонсгол даргалагчийг томилсон тогтоолыг баталсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3-д Байнгын хороо сонсгол зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж болно гэж заасны дагуу Ажлын хэсэг байгуулах тогтоолын төслийг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу, нэрс өгнө үү? Асуулт асууж, үг хэлэх хүүхэд байхгүй байна. Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Тэгэхдээ гишүүдэд нэг анхааруулж хэлэх хэрэгтэй байна. Энэ Их Хурлын дарга манай Байнгын хороог цохож цохолт хийгээд явуулсан учраас бид дэмжсэн. Тэгэхдээ 2008 оноос хойш гэдэг чинь бараг хориод жилийн өмнөх асуудлыг архив энэ тэрээс гаргах асуудал байж байна. Энэнээс хойш асуудлыг сүүлийн 5 жил юм уу, юугаар тусга гэдэг асуудлыг тавьсан байгаа. Энийг анхаараарай гээд хэлье.

Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсгийг үндэслэн БОХХАА-н байнгын хорооноос тогтоох нь:

1.ХХААХҮ-ийн салбарт 2008-аас хойших хугацаанд төрөөс олгож байгаа дэмжлэг, урамшуулал, ЗГ хариуцсан төлж байгаа зээлийн хүүгийн татаас олголтын байдал, хэрэгжилт сэдэвт ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч М.Мандхай Улсын Их Хурлын гишүүн, гишүүд Х.Баасанжаргал Улсын Их Хурлын гишүүн, Б.Баярбаатар Улсын Их Хурлын гишүүн, Ж.Батбаатар Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, С.Ганбаатар Улсын Их Хурлын гишүүн, М.Ганхүлэг Улсын Их Хурлын гишүүн, Л.Мөнхбаясгалан Улсын Их Хурлын гишүүн, Р.Сэддорж Улсын Их Хурлын гишүүн, А.Ундраа Улсын Их Хурлын гишүүн, Б.Уянга Улсын Их Хурлын гишүүн. Энэ ажлын хэсэг сондгой байх ёстой энэ 10 болчихсон байна, 1 гишүүн энэ юун дотроос нэмэх юм уу? Замира гишүүн ажлын хэсэг. Замира гишүүн уул нь санал гаргасан байна, нэмж оруулъя.

2-т ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг Ажлын хэсэг /М.Мандхай/-т зөвшөөрсүгэй.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Б.Бейсен/-нд даалгасугай гэсэн тогтоолын төсөл байна. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдгээр санал хураалт явуулъя. Түрүүн асуулт, тогтоолын төсөл дээр үү? Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асууя гэж байна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. 2008 оноос хойших төрөөс олгож буй дэмжлэг, урамшуулал, ЗГ-ын хариуцан төлж байгаа зээлийн хүүгийн татаас олголтын байдал хэрэгжилт буюу ХХААХҮЯ-тай холбоотой салбартай холбоотой асуудал. Нэг ёсондоо бас ЖДҮ явж байгаа байх тийм ээ. Энэ ажлын хэсэг дотор маань зээл авч байсан эрх ашгийн сонирхолтой хүн байгаа юу, үгүй юү магадгүй? Байгаа бол ажлын хэсгээс хасах, байхгүй гэвэл асуудал алга. Энийг тодруулсан болов уу, үгүй болов уу давхар? Үгүй ээ мэдэхгүй байна. Зүгээр тэгж, зүгээр л асууж байгаа ер нь. Юмыг яаж мэдэх вэ.

Б.Бейсен: Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Ямар ч байсан энэ гишүүдээсээ санал авсан. Тэгээд ямар нэгэн яг энэ зээл, татаас, урамшуулалтай нэр холбогдож байсан, тодорхой хэмжээний ямар нэгэн байдлаар холбогдох тэр өөрийнх нь компани ч гэдэг юм уу ийм хүмүүс зээл, урамшуулал татааст хамрагдаж байсан ийм гишүүд байхгүй гэж үзсэн учраас дараах гишүүдийг, дээрээс нь нам намын төлөөллөөс нь ингээд оруулсан байгаа. Тэгээд хариуцлагатай бол байхгүй гэдгийг нь хэлье.

Б.Бейсен: Болсон уу Бат-Эрдэнэ гишүүн? Гишүүд асуулт асууж дууслаа. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдэг санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Гишүүд санал хураалтад бэлдээрэй бас дутчихаад байна. Санал хураалт. 64,7 хувиар дэмжигдлээ. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

15.42 цаг

Гурав.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Дараагийн асуудалд оръё. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан /ЖДҮХС/-гаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцах. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгээ оруулаарай. Ажлын хэсэг оруулаарай. Ирсэн байна уу? Б.Сугарбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Я.Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэр /ЖДҮ/-ийн газрын дарга, Ч.Сугар ЖДҮ-ийн газрын Хууль, тусгай активын хэлтсийн дарга гээд ирээгүй байна.

БОХХАА-н байнгын хорооны 2025 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт гаргасан байна. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Бат-Эрдэнэ гишүүний, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүний микрофон өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын БОХХАА-н байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 2 дугаар тогтоолоор ЖДҮ-лэлийг хөгжүүлэх сангийн зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан ЖДҮ-лэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ миний бие, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, С.Ганбаатар, М.Ганхүлэг, С.Замира, У.Отгонбаяр нар ажилласан. Мөн Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиг үүрэгтэйгээр Улсын Их Хурлын Тамгын газар, ХХААХҮЯ, ЖДҮ-лэлийн газар, нийслэлийн 9 дүүргийн бизнес эрхлэгчдийн төлөөллийн бүрэлдэхүүн ажиллаж ажлын хэсгийн 2 хуралдаанаар, 2 удаагийн хуралдаанаар уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 82 дугаар захирамжаар байгуулагдсан ЖДҮ-лэл үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, бичил үйлдвэрлэлийг дэмжих тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг, Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан өрхийн бичил ЖДҮ-лэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаатай уялдан ажиллалаа.

Ажлын хэсгийн, хэсгүүдийн хуралдаан жижиг, дунд бизнес эрхлэгчдээс авсан санал асуулгын дүгнэлт, цуврал хэлэлцүүлгээс гарсан санал, бичил, жижиг, дунд бизнест төрөөс үзүүлж байгаа дэмжлэгийн талаарх гадаад орнуудын туршлагыг судалж үзэн дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар

зүйлийн 22.3.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж танилцуулж байна.

1.ЖДҮ-лэлийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн талаар. ЖДҮ-лэлийг хөгжүүлэх сан улсын төсөв, ЗГ-ын бонд, Хөгжлийн банкны дамжуулан зээл болон орон нутгийн төсвөөс нийт 743,9 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг өнгөрсөн хугацаанд бүрдүүлж, 9272 төсөлд 1,1 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна. ЖДҮ-лэлийг хөгжүүлэх сан нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1994 зээлдэгчийн 218,1 тэрбум төгрөгийн зээлийн авлагатай бөгөөд 7978 зээлдэгч 938 тэрбум төгрөгийн зээлийг бүрэн төлж барагдуулсан байна. ЖДҮ-лэлийг хөгжүүлэх санд 2020 оноос хойш улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэр олгогдоогүй бөгөөд зээлийн эргэн төлөлтөөс сангийн эх үүсвэрийг бүрдүүлэн хөнгөлөлттэй зээлийг олгож, 2002 он хүртэл зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс Хөгжлийн банкны болон ЗГ-ын бондын урт хугацаат өр нийт төлбөр нь 123 тэрбум төгрөгийг төлж, бусад төлөх өр төлбөрийг бүрэн барагдуулсан.

2009-нөөс 2025 оны хооронд 2441 иргэн, ААН-ийн 575,4 тэрбум төгрөгийн төгрөг буюу 50,8 хувь санхүүжилтийг Улаанбаатар хотод, 6831 зээлдэгчийн 558,3 тэрбум төгрөгийн буюу 49,2 хувийн санхүүжилтийг орон нутагт олгосон бөгөөд орон нутагт 24,885 ажлын байр хадгалж, 31027 ажлын байр шинээр нэмэгдүүлж, нийт 41044 ажлын байр хадгалж, 56084 ажлын байр шинээр нэмэгдүүлсэн байна. ЖДҮ-лэлийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхдээ Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын хүрээнд батлагдсан ЗГ-ын зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр зээл олгосон байна. ЖДҮ-лэлийг хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийн авлага 2026 оны эхний улирлын байдлаар 265 зээлдэгчийн 97,3 тэрбум төгрөг байна. Энэ нь нийт олгосон зээлийн 2,8 хувийг эзэлж байгаа.

Хууль болон тусгай актын нэгж байгуулан өр барагдуулах ажлыг боломжийн сайн гүйцэтгэсэн гэж дүгнэхээр байна. Нийт чанаргүй авлагын 92 хувь нь буюу 89,2 тэрбум төгрөгийн зээл нь 2019 оноос өмнө олгогдсон бөгөөд чанаргүй зээлийн авлагын 78 хувь буюу 75,9 тэрбум төгрөг нь шүүхийн захирамж шийдвэрээр баталгаажсан байна. Тус санд 2020 оноос хойш улсын төсвөөс санхүүжилт хуваарилаагүй. Харин сангийн өр төлбөр болох ЗГ-ын бонд болон Хөгжлийн банкны өр төлбөрийг өөрийн хөрөнгөөр, өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр төлж дуусгалаа.

Сан нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 265,5 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байна. Хэлэлцүүлэг хамтарсан хуралдааны үр дүнгээс харахад ЖДҮ-лэл, үйлчилгээний салбарт дараах хүндрэлүүд байгааг тодруулж байна. Үүнд, салбарын нэгдсэн бодлогын уялдаа сул, төрийн байгууллагуудын чиг үүрэг давхардсан, хариуцлагын тогтолцоо тодорхой бус, санхүүжилтийн хүртээмж муу, зээлийн эх үүсвэр дутагдалтай. Барьцааны шаардлага өндөр, зээлийн эргэн төлөлтийг сайжруулах шаардлагатай байгаа. ЖДҮ, үйлчилгээ эрхлэгчид үзүүлэх татварын хөнгөлөлт урамшууллын эрх зүйн орчин байхгүй. Экспортын нэгдсэн бодлого дутмаг, гадаадын худалдааны эрх зүйн орчин хангалтгүй, гадаад худалдааны эрх зүйн орчин хангалтгүй. Хүний нөөцийн чадавх сул, сургалт, стандартын тогтолцоо дутмаг байгаа нь харагдаж байна.

Бодлогын тулгамдсан асуудлуудын хүрээнд санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх, жил бүрийн улсын төсөвт тусгах, ЖДҮ-лэлийн санхүүжилт, экспортын дэмжлэг хоорондын уялдаа хангалтгүй байна. Татварын орчин бизнесийн хөгжлийг

дэмжихгүй, өсөлтийг хязгаарлаж байна. Импортын зохицуулалт сул, дотоодын үйлдвэрлэл хангалтгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бичил бизнес эрхлэгчдэд чиглэсэн бодлого саланги, үр дүн хангалтгүй байна. Зээлийн тогтолцоо богино хугацаатай, тогтвортой өсөлтийг дэмжихгүй байна. Үйлдвэрлэл, үйлчилгээ салбарын, худалдааны салбарын дэмжлэг тэгш бус байгаа нь харагдаж байна. Мөн түрээс, дэд бүтэц, үйлдвэрлэлийн орчны асуудал хангалтгүй байна.

Санхүүжилтийн хүртээмжийн хувьд урт хугацааны 10-аас 30 жилийн хөнгөлөлттэй зээлийн тогтолцоог нэвтрүүлэх, шатлан санхүүжүүлэх механизм хэрэгжүүлэх, ЖДҮ-т зориулсан банкны тогтолцоог бий болгох, батлан даалтын тогтолцоог хөгжүүлэх, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн бүтээгдэхүүнүүдийг нэмэгдүүлэх. Татвар, эрх зүйн орчны хувьд нэмэгдсэн өртгийн албан татварын босгыг 400 сая төгрөгт хүргэх, ЖДҮ-лэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд ангиллын шинэчлэн, ангиллыг шинэчлэн тодорхойлох. Эмэгтэй гарааны бизнес эрхлэгчдийг тодорхойлох, ЖДҮ-лэл эрхлэгчид нийгмийн даатгалын шимтгэл /НДШ/, хүн амын орлогын албан татварын өөрчлөлтийн уян хатан механизмыг нэвтрүүлэх, борлуулалтыг дэмжих бүх төрлийн арга хэмжээ зохион байгуулах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа дээр тулгуурласан борлуулалтын сувгуудыг бий болгох зайлшгүй шаардлагатай харагдаж байна. Хүний нөөцийн бодлогын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилладаг ААН-үүдэд татвар, санхүүгийн бодит дэмжлэг үзүүлэх, халамжийн бодлогыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой уялдуулах, үйлдвэрлэл үйлчилгээ стандарт, үйлдвэр, үйлчилгээний стандарт, сургалтын нэгдсэн тогтолцоог бий болгох зэрэг.

Дэд бүтэц, бизнесийн орчны хувьд үйлдвэр технологийн парк байгуулах, хөнгөлөлттэй түрээсийн орчин бүрдүүлэх, түрээсийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, түрээсийн, бизнесийн түрээсийн дарамтыг бууруулах, бизнесийн зөвлөх үйлчилгээний төвүүдийг өргөжүүлэх шаардлагатай харагдаж байна. Ингээд дүгнэлтийн хүрээнд бизнесийн орчныг дэмжих, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхийн тулд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал байна. Үүнийг батлахын тулд төрөөс, төрийн зүгээс дэмжлэгийн хөтөлбөрүүдийг уламжлалт байдлаас илүү гүнзгийрүүлж, урт хугацааны бизнесийг дэмжих шаардлагатай харагдаж байна. Хөрөнгө оруулалтыг дэмжих, бизнесийн хүрээнд бизнес хөгжлийг дэмжих зориулалтаар гаргасан хөрөнгө оруулалтыг зөвхөн ажилтай бизнесүүдэд чиглүүлэх хэрэгтэй. Амжилттай явж байгаа бизнесүүдэд чиглүүлэх, эрсдэл багатай итгэмжлэгдсэн бизнесүүдэд төсвийн хөрөнгийг зарцуулах нь үр дүнтэй байж, эрсдэлийг зайлсхийх боломжийг олгоно. Цаашид олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай. Үүний хүрээнд Монгол Улсын жижиг, дунд бизнесийн салбарыг хөгжүүлэхийн тулд эдийн засгийн бусад салбаруудтай, ялангуяа гадаад зах зээлтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай. Тухайлбал экспортын асуудлыг бизнес эрхлэгчдэд зориулан хуулийн хүрээнд зохицуулах, олон улсын зах зээлд гарах боломжийг нээх гэх мэтчилэн байна.

Төрийн бодлого, хууль, эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд. Хуулийн хүрээнд ЖДҮ-лэлийн үйлчилгээнд хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн хугацааг уртасгах, хүүгийн хэмжээг бууруулах, хүүгийн татаас олгох, батлан даалт гаргах, тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй түрээсийн үйлчилгээ, татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг санхүүгийн дэмжлэг үзүүлэх, мөн экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг болон кластер хэлбэрээр ажилладаг үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих, төрийн худалдан авалт, бизнесийн.../минут дуусав/

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүнд микрофон өгье. Дуусчхаад байгаа юм уу. Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Мандхай гишүүнээр тасалъя. Батчимэг гишүүний нэрийг нэмье асуулт асуух гишүүнээр. Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Энэ ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцлаа. Тэгээд эндээс нэг яах вэ зээл аваад тэдэн төлөлттэй байна, төдий хэмжээний зээлийн авлагын үлдэгдэлтэй байна гэдэг тоог бол зээл олгосон юм чинь энэ тоо хэмжээг хөөгөөд гаргачих байх боломжтой байх. Нэг гол энэ дээр ингээд санал, дүгнэлт дээр ойлгогдохгүй, магадгүй мэдээлэл дутмаг, хүсэж байгаа мэдээлэл юу вэ гэхлээр жижиг, дунд бизнес, ЖДҮ-лэлээс ингээд ЖДҮ-ээс зээл аваад, хэчнээн ААН-ийн, ямар салбарууд, хэдий хэмжээний энэ зээлийг аваад, ямар үр дүн гарсан юм бэ гэдэг ийм тоон мэдээлэл хэрэгтэй байна. Энэ дээр жишээлбэл ямар бүтээмжийг бий болгосон юм, ажлын байрууд дурдсан байна. Гэхдээ яг үндсэн гол яг энэ үйлдвэрлэл яаж өргөжиж, хөгжсөн юм, ямар салбарууд нь босож ирсэн юм гэдэг талаар мэдээлэл ерөөсөө харагдахгүй байгаад байна. Тэгээд энэнтэй холбоотой мэдээлэл тоо баримтууд гарсан уу? Хэчнээн бизнесүүд эндээс гарааны бизнесүүд боссон юм бэ, эндээс гарч байгаа яг out put буюу яг гарц хэмжээ нь ямар байгаа юм, ямар үр дүн гарсан юм, бүтээмж хэдээр нэмэгдсэн юм, энэний яг энэ ЖДҮ-лэлийн зээлийг аваад үр дүн нь яг ямар хувьтай байсан юм гэдэг ийм нарийн мэдээлэл нэгд харагдахгүй байгаад байна. Бид нэгэнт зээлийн асуудлыг ярьж байгаа бол яг энэ үр дүнтэй нь уялдуулж хэмжигдэхүйц байдлаар нь яривал илүү үр дүнтэй юм болов уу?

2 дугаарт энэ дүгнэлт дээр бизнесийн орчныг дэмжих дээр энийг сайн ойлгохгүй байна. Үүнийг бататгахын тулд төрийн зүгээс дэмжлэгийн хөтөлбөрүүдийг уламжлалт байдлаас илүү гүнзгийрүүлж гэж яг юу гэсэн үг юм бэ? Энэ дээр нэг тайлбар өгөөч.

Б.Бейсен: 6 номер хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Мандхай гишүүний асуултад хариулъя. ЖДҮ-ийн газар Эрдэнэсайхан. Бид энэ зээл олгохдоо төрөөс олгож байгаа томоохон бодлогуудтай уялдуулж зээлүүдээ олгож байгаа. Жишээ нь хүнсний хувьсгалтай уялдуулаад гэхэд яг үнэнээ хэлэхэд 19 оноос өмнө тоо баримт юмнууд байдаггүй юм. Тэгэхээр бид 19 он буюу агентлаг байгуулагдсанаас хойш бүх статистик тоонуудаа аваад ингээд нэгтгээд явж байгаа. Хүнсний хувьсгал дээр гэхэд нийтдээ 763 ААН-д 98 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Эндээс 3912 ажлын байр шинээр бий болсон байна, 2700 ажлын байр хадгалагдсан байна. Цагаан алт 79 төсөлд 7,5 тэрбум төгрөг өгөөд, 405 шинэ ажлын байр бий болж, 265 ажлын байр хадгалагдсан. Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд 19 төсөлд зээл олгож, 1,9 тэрбум төгрөгийг олгосон 119 ААН, юу 119 ажлын байр шинээр бий болж, 103 ажлын байр хадгалагдсан.

Хөдөө орон нутаг руу шилжих хөдөлгөөнийг дэмжих бодлого 28 ААН-д зээл 3,4 тэрбум төгрөгийн зээл олгосон. Үүнд 112 ажлын байр шинээр бий болж, 85 ажлын байр хадгалагдсан. Нийтдээ ер нь 20-оос 25 оны хооронд 1055 ААН өргөтгөсөн, шинээр 255 ААН-ийг шинэ үйлдвэр бий болсон гэсэн. Мөн 41 мянган ажлын байр 9 оноос хойш олгосон хугацаанд хадгалсан, 56 мянган ажлын байр бий болгосон гээд ингээд тодорхой үр дүнгүүдийг гаргаж явж байгаа. Мөн шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбоотойгоор хоршоодод зээл олгосон. Энд 97 загвар хоршоонд 10,6 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Тэгээд 540 ажлын байр бий болж, 463 ажлын

байр хадгалагдсан гээд. Сүүлийн 20 оноос хойших статистик тоонууд гараад, хэдэн ААН-д, ямар зээл олгогдоод, араас нь хяналт тавиад, зээл нь төлөгдөж байна уу, үгүй юу гээд ингээд бүх юм явж байгаа. Чанаргүй байгаа зээлийн хувьд өмнө олгосон буюу 18, 9 оноос өмнө олгогдсон зээлүүд дээр одоо хууль хяналтын байгууллагад хандах маягаар ингээд явж байна.

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Эрдэнэсайхан дарга 2019-өөс өмнөх тоо баримт байхгүй байж болно. 19 оноос хойш энэ чинь 7-гоос бараг 8 жилийн хугацаа өнгөрсөн байна. Энэ хугацаанд олгогдсон зээлийн, ингээд хэдүүлээ нийт тэдэн ААН тэдэн төгрөг аваад, тэдэн төгрөгийн үлдэгдэлтэй, тэдэн төгрөгийн авлагатай гэж ярьдаг юмаа болимоор байна. Энэ татвар төлөгчдийн энэ мөнгийг эргэлдүүлж л байгаа юм бол бид энэ ХАА-н салбарын энэ ЖДҮ-лэл эрхлэгчдийн яг энэ зээл олгож байгаа үндсэн зорилго чинь яг юу юм бэ, энийгээ хэдүүлээ нэг ойлголтод хүрэхгүй бол ийм хариулттай явбал бид ер нь цаашдаа энэ ЖДҮ-лэлийн зээл ер нь үр дүнгүй олгогдоод, дахиад нөгөө хуучин кейс давтагдах уу гэсэн эрсдэл харагдаж байна. Энэ чинь ямар бүтээгдэхүүн үйлдвэрлээд байгаа юм, ямар төрлийн бизнес ААН-үүд дийлэнх нь авч байгаа юм? Үүнээс тэдэн ажлын байр бий болоод, тэчнээн үйлдвэрлэлийн тоо хэмжээ нэмэгдсэн байна, импортыг орлох.../минут дуусав/

Б.Бейсен: 6.

Я.Эрдэнэсайхан: Тодруулгад нэмж хариулъя. ЖДҮХС-гаас олгож байгаа зээлийн үндсэн зорилго бол ажлын байр бий болгох. Тэгээд би тайлан дээр сая байна, би сая хэллээ. Хэдэн ажлын байр бий болсон юм, хэдийг хадгалсан юм гэдгийг. 2 дугаарт нь шинээр үйлдвэр хэдийг бий болгосон юм бэ. Бүтээгдэхүүнүүдийн талаар судалгаа байгаа. Нэг үйлдвэр 100 саяын зээл авахад хэдэн төрлийн бүтээгдэхүүн бий болсон юм гээд. Нийтдээ 9 мянга гаруй энэ зээлдэгчийн асуудал л даа. Тэгэхээр энийг хэдэн төрлийн бүтээгдэхүүн гэдгийг, нэмэгдсэн юм бэ гэдгийг танд тоогоор хүргүүлъя. Ер нь сүүлийн үед Монгол Улс ХАА-н орон учраас ХАА дээр суурилсан үйлдвэрлэлийг дэмжих бодлого барьж байгаа. Мэдээж Монгол Улсын төрөөс баримталж байгаа бодлогууд, түүн дээр нэмээд дандаа үйлдвэрлэлийг дэмжих, өөрөөр хэлбэл худалдаа, үйлчилгээгээ хойш нь орхиод, хийж бүтээж байгаа.../минут дуусав/

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Ялангуяа ХАА-н гаралтай түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгох ийм үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлж байгаа.

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: ЖДҮ-лэлийн зээл бол ажлын байрлал бий болгох зорилготой зээл юм бол хэдүүлээ энэ зээлийн асуудлыг бүтцээр нь ер нь дахиж нэг харахгүй бол болохгүй юм байна гэж хэлмээр байна. Манайх энэ ЖДҮ-лэлийн газар ХААЯ өөрөө энэ Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны үйл ажиллагааг хийдэг болчихсон юм уу? Зөвхөн ажлын байр бий болгох зорилготой ийм байгууллага болчихсон юм уу? Эндээс чинь бүтээмж бий болоод бид яаж импортоор, импортоос хангаж байгаа энэ бүтээгдэхүүнийг ЖДҮ-лэлийн зээлээр дотоодын энэ жижиг, дунд бизнесүүдээ дэмжээд, энэ орлох бүтээгдэхүүнийг бий болгох вэ гэдэг бид

бүтээгдэхүүн нийлүүлэлт, үр дүн, бүтээмжийн асуудлыг л ярьдаг байхгүй бол ажлын байр бий болгодог зээл юм бол бид дахиж энэ ЖДҮ-лэлийн ер нь энэ агентлаг ер нь байх эсэх асуудлыг бид дахиж ярих шаардлагатай юм байна гэдэг би дүгнэлтэд хүрч байна.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Мандхай гишүүний ярьж байгаатай санал нэг байгаад байгаа юм. Хэдийгээр ХАА-н, ХААЯ-ныхаа дэргэд байгаа ч гэсэн яг өгч байгаа зээл тэр тусмаа 19 оноос өмнөх нь бол ерөөсөө үйлдвэрлэл, үйлчилгээ бүр ерөөсөө ажлын байр нэмэгдүүлэх л асуудлын хүрээнд энэ зээлүүд олгогдож байсан. Тэгэхээр сүүлд бидний тавиад байгаа Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тавьж байгаа асуудлууд, дээрээс нь ажлын байрыг, ажлын байр нэмэгдүүлэх, хүнсний хангамжийг сайжруулах Хүнсний хувьсгал бодлого, Цагаан алт гэсэн энэ хөтөлбөрүүдийн хүрээнд ер нь чиглүүлэх, энэ бизнесийн хүрээг нэмэгдүүлэх гэсэн ийм бодлогыг гаргах, дээрээс нь энийгээ засаж залруулах гэдэг утгаар нь яваад байгаа юм. Тэр тусмаа сүүлийн 2, 3 жилийн хугацаанд ерөөсөө нэг ч төгрөг төсөв дээр тавьж, ЖДҮ-лэлийг бид дэмжээгүй. Үндсэндээ энэ хөтөлбөрүүдийн хүрээнд энэ үйлдвэр.../минут дуусав/

Б.Бейсен: 6 номер хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Үнэхээр сүүлийн 6, 7 жил улсын төсөв дээр мөнгө тавигдаагүй. Тийм учраас өмнө нь олгож байсан зээлээ эргэн төлүүлээд, тэр муу зээлүүдээ төлүүлээд ингээд явж байгаа. Тэгэхээр төсөв санхүүгийн хувьд бол маш хангалтгүй байгаа. Тийм учраас бид маш өндөр шалгуураар, тодорхой нэлээн шалгаж байж өгч байгаа. Төсөв, санхүү тавиад өгвөл энэ ажлын байр бий болгох, бүтээмж нэмэгдүүлэх энэ чиглэл рүүгээ хандаад, энэ зээлийн хугацаагаа уртасгах, сонгон шалгаруулалтын хугацааг багасгах ийм үүрэг даалгаврууд өгөгдөөд эхнээсээ хэрэгжээд явж байгаа. Зүгээр өнгөрсөн жилүүдэд өгсөн нийт 9200 зээлдэгчийн хувьд хүнсний үйлдвэрт 1500, хөнгөн үйлдвэрт 2400, газар тариаланд 976, МАА-д 1200 гээд ингээд салбараараа таны түрүүний хэлснээр өгөгдсөн зээлүүдийн тоо бий. Энүүгээрээ дагаад бүтээмжийн.../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Төрийн аудитын байгууллагын 2025 оны тайланд ЖДҮ-лэлийн сантай холбоотой нэг асуудал байгаа. Би энийг л асууя гэж бодож байна л даа. ХХААХҮЯ-ны баталсан салбар чиглэлд хамаарахгүй 25 ААН-д 2,8 тэрбум төгрөгийн зээл олгосон. Улсын бүртгэлд огт байхгүй чиглэлээр зээл олгосон. Нийт зээл нь 3,9 тэрбум төгрөг болчихоод байгаа юм. Ийм тайлан ирүүлсэн Төсвийн байнгын хороогоор орсон. Энэ ямар учиртай юм бэ? Яахаараа улсын бүртгэлд байхгүй, энэ яамнаас баталсан салбар чиглэлд хамаардаггүй, тухайн ААН-ийн чиглэл нь зөрсөн байхад 3,9 тэрбумыг олгосон байдаг вэ, эсвэл ийм чиглэлд хамаарахгүйгээр зээл олгох эрх нь байна уу? Энд хариултаа авъя.

Б.Бейсен: 6 номер хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Тухайн жилд зээл олгох салбар чиглэлийг салбарын сайд баталж байгаа. Сайдын олгосон, баталсан салбар чиглэлийн дагуу олгож байгаа. Энэнээс зөрсөн асуудал байхгүй.

Өмнөговь аймаг дээр салбар чиглэл харгалзахгүйгээр олгож байгаа юм. Тэгэхээр энийг аудитын байгууллага хараагүй юм болов уу гэж бодож байна. Өмнөговь аймаг орон нутгийн төсвөөсөө 5 тэрбум төгрөг хуваарилсан, ингээд аймгийн хэмжээнд хангалттай потенциал нь байгаа буюу ЖДҮ-ийн салбарт хамаарч байгаа бүхий л хүн хүсэлтээ өгөөд, сонгон шалгаруулалтад ороод авч болно. Бусад аймгуудын, Улаанбаатар хотын хувьд гэхэд нөгөө бага мөнгийг олон зээлдэгчид өгч байгаа учраас жишээлбэл энэ жил ноосонд өгнө, ноолуурт өгөхгүй ч гэдэг юм уу ингэж салбар чиглэлээ тогтоож өгдөг. Энэний дагуу олгогдож байгаа юм.

Улсын бүртгэлд заагаагүй салбар чиглэлд олгоно гэж байхгүй. Бид ЖДҮ эрхлэгч мөн байна уу, дээрээс нь тухайн салбар чиглэлтэй ямар үйл ажиллагаа явуулж байна вэ гээд сонгон шалгаруулалтыг түрүүн би хэлсэн маш нягт, нэлээн олон шат дамжлагатайгаар, яг үнэндээ хэлэхэд бага мөнгийг их олон зээлдэгчид өгдөг, араас нь маш их гомдол гардаг учраас ямар ч алдаа мадаггүй сонгон шалгаруулахын тулд энэ аргачлалыг маш нарийн хийж өгсөн. Өөрөөр хэлбэл нэг талдаа хүнээ хамгаалж байгаа, нөгөө талдаа яг асуудалгүйгээр энэ сонгон шалгаруулалт эзэндээ очиж байгаа. Тийм учраас би өмнө Байнгын хороон дээр танилцуулж байсан Авлигатай тэмцэх газар /АТГ/-ын сүүлийн 3, 4 жилийн үнэлгээгээр тогтмол эхний 1, 2 байранд ил тод, шударга болсон байна гээд явж байгаа.

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Тэгээд тодруулсандаа, баримтыг шалгасан. Төрийн аудитын газраас надад 25 ААН-ийг хэдэн төгрөг авсан, ямар үйл ажиллагаатай газар, ямар ХХАА-н сайдын баталсан салбарын нэрнээс зөрүүлж өгсөн нь яг энд 25-уулаа байна. Би зүгээр ААН-үүдийг юун түрүүнд нэг их дурдахгүйгээр хэлж бас болж байна зээл нь. Гадаад, дотоод худалдаа эрхлэх үйл ажиллагаа явуулдаг компанид мах махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлтэй сайдын 122 сая 200 мянгыг олгосон байх юм гэх мэтчилэнгээр, хуурай замаар ачаа тээвэр тээвэрлэдэг компани сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах 91 сая төгрөгийг олгосон байх юм, судалгаатай яриад байна л даа. Энэ бүгд Өмнөговийнх гэж үү, үгүй байх. Автомашины засвар үйлчилгээ эрхлэх компанид 293 сая төгрөгийн зээлийг хүнсний зорь.../минут дуусав/

Б.Бейсен: 6 номер хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Бүх 25 компанийнх нь нэрээр нь аваад танд би танилцуулъя. Ер нь улсын бүртгэл дээр, улсын бүртгэлийн гэрчилгээ дээрээ салбар чиглэлийнхээ бичүүлээгүй мөртөө тэр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг маш олон компаниуд байдаг. Өөрөөр хэлбэл таны хэлээд байгаа юу гэдэг юм ложистикийн үйл ажиллагаа явуулдаг мөртөө махны үйлдвэр байгуулчихсан, тэрийгээ үйл ажиллагаа явуулж байгаа зөвхөн улсын бүртгэлийн гэрчилгээ дээр бичээгүйгээс нь болоод ингэж хязгаарлах зохицуулалт байхгүй л дээ.

Б.Бейсен: Батчимэг гишүүн асуулт асууя. Та 2 удаа асуучихсан, тийм үү. 2 тодруулчихсан байна. Батчимэг гишүүн. Батчимэг гишүүн. Батчимэг микрофоныг минутыг нь эхнээс нь дахиж өгөөрэй.

П.Батчимэг: Минутаа эхнээс нь авчихъя. ЖДҮ-ийг хөгжүүлэх энэхүү сан ер нь өнгөрсөн хугацаанд үүргээ гүйцэтгэж, ингээд сайнтай, муутай 2 талтай явж ирсэн.

Үнэхээр ЖДҮХС бол цэвэр бизнесийг дэмжих, ЖДҮ-лэл бизнес эрхлэгч эрхлэгч энэ иргэдээ дэмжих ийм зорилготой явж ирсэн. Өнөөдөр энэ санал, дүгнэлт гаргаж байгаа ажлын хэсгээс танилцуулгаас харахад олон ажил хийсэн юм шиг байна. Мэдээж цаг хугацааны хувьд ч гэсэн 2025 оны 1 дүгээр сард 14-нд энэ ажлын хэсэг байгуулагдаад, өнөөг хүртэл бараг жил 5, 6 сарын нүүр үзэж байгаа юм байна. Тэгэхээр энэ дотор энд ажлын хэсгийн гаргасан дүгнэлт дотор яг энэ манай ажлын хэсэг Их Хурлын юунаас томилогдсон энэ ажлын хэсэг эцсийн дүндээ ер нь энэ ЖДҮ хөгжүүлэх санг цаашид нь ер нь яг тогтолцооны хувьд яаж өөрчлөх гээд байгаа юм, яаж шинэчлэх гээд байгаа юм энэ зорилгыг нэг тодруулаад асуучихъя?

Эргэлзээтэй нэг хэд хэдэн зүйлүүд байгаад байх шиг байна. Энэ Гэр бүл, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөр эрхлэлтийн сан гэж байдаг. Энэ хүний нөөц нийгмийн бодлого гэсэн энэ хэсэг дээр энэ яамны бас энэ юу давхардчихсан байх шиг. Халамжийн бодлого, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого шинэчлэх гээд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилладаг ААН-үүдэд татвар, санхүүгийн бодит дэмжлэг үзүүлэх гээд. Дараа нь болохоор энэ дэд бүтэц, бизнесийн орчин дээр үйлдвэр технологийн парк байгуулж гэж байгаа юм. Энэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь энэ өөрөө тусдаа хуультай. Тэгэхээр энэ Үйлдвэр технологийн эрх зүйн байдлын тухай хууль энд үйлчилж байгаа шүү дээ тийм ээ. Тэгэхээр энэ яамдын яагаад энэ хамаарах асуудлууд энд яагаад ороод ирэв гэдэг энэ санал, дүгнэлтэд нэг?

ЖДҮ эрхлэгчдийн тулгамдсан асуудлууд зөвхөн нэг салбарт биш, бүх салбарт үүссэн асуудлуудыг ингээд шийдэх юм шиг ийм санаа агуулаад ороод ирлээ л дээ. Зүгээр өөрчлөх гээд байгаа, шинэчлэх гээд байгаа хууль, эрх зүйн орчин, татварын орчин, энэ санхүүгийн хүртээмж, ер нь цаашдаа энэ ЖДҮ сан байх юм уу, үгүй юү, энд ЖДҮ-ийн газар нь ч гэсэн оршин тогтнох эсэх асуудал яригдах байх гэж бодож байна энэ ажлын хэсгийн дүгнэлтийн юугаар үр дүнгээр. Тэгэхээр энэ эргэлзээтэй асуудлуудыг нэг тайлбарлаад хэлээд өгөөч Бат-Эрдэнэ дарга.

Б.Бейсен: Ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ дарга хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: ЖДҮ-лэлийг хөгжүүлэх сан маань цаашдаа ажиллана. Бид урьд нь төсвөөс мөнгө тавиад, тэрнийхээ хүрээнд зээлийг нь олгодог байсан. Энэ дээр нэлээн том дутагдлууд гараад, ЖДҮ-тэй холбоотой асуудлууд нэлээн гарсан шүү дээ. Замбараагүй зээл олголоо гээд. Тэгээд энэ хүрээндээ яаман дээр тодорхой асуудлууд гарч байгаад зээл олгох журмаа өөрчлөөд, аймаг, орон нутагт тодорхой хэмжээний зээлийн процентын 40-чөөд хувийг аймаг, орон нутагт олгож байгаа. Аймаг, орон нутагт олгодог болоод, аймаг, орон нутагт ЖДҮ сангийн зээлэн дээр олон нийтийн оролцоог оруулдаг болгоод, сонгон шалгаруулалтыг нь сайжруулаад, ил тод болгоод эд нар ингээд хийгээд явсан ажлууд нэлээн зохион байгуулагдсан.

Сүүлийн үед Сангийн яамнаас барьж байгаа бодлого нь зах зээл өөрөө өөрийгөө зохицуулах ёстой. Бид зах зээлийн энэ асуудалд орох ёсгүй гэсэн нэг ийм бодлого бариад байгаа юм. Тэр утгаараа төсөв дээр мөнгө тавьдаг асуудал нь сүүлийн жилүүдэд бид больсон. Гагцхүү зүгээр одоо явж байгаа асуудлууд нь нөгөө цагаан алт хөтөлбөр, нөгөөдөх нь хүнсний хувьсгал гэсэн энэ хөтөлбөрүүдийн хүрээнд зээл олгож байгаа юм. Түүрүүн тэндээс тайлбарласан шүү дээ. Ер нь тухайн зээл хаашаа олгох вэ гэдгийг ерөөсөө яг энэ үйлчилгээний салбарт олгоё, эсвэл МАА руу олгоё, эсвэл газар тариалан руу олгоё ч гэдэг юм уу энийг тухайн сайд шийдвэрлээд байгаа юм. Тухайн жилийн бодлогыг сайдаас тодорхойл гэж гаргаж

ирж байгаа юм. Урьд өмнө хамаагүй зээл олгож байсан бол одоо сайдаасаа яг тодорхой чиглэл гаргая, дээрээс нь саяын гаргасан хөтөлбөрүүдтэй уялдуулж энэ зээлээ олгодог болгоё гэсэн нэг ийм бодлогыг гаргаад байгаа.

Үндсэн чиглэл дээр нэлээн өөрчлөх асуудлууд харагдаж байна. Жишээ нь таны сая асуулт гарч ирж байна шүү дээ. Яг цаашаа байх юм уу, байхгүй юм уу. Хүнсний хувьсгал эд нар гээд л бид ийм хүн хөнгөлөлттэй том зээлүүдээ гаргаад ингээд явах юм уу. МАА руу цагаан хувьсгал эд нар гээд МАА-н бүтээгдэхүүнийг боловсруулах чиглэл рүү гаргах юм уу эд нар гээд нэлээн бидний эдийн засаг хөгжөөд ирэх тусам, эдийн засаг тэлээд ирэх тусам бидний гаргах зээлүүд маань яг ЖДҮ сангаар гаргаж байгаа зээл маань хэтэрхий багадаад болчхож байгаа юм. Тэгээд тийшээгээ оруулж байгаа бидний улсын төсвөөс тавьдаг мөнгө маань өчүүхэн зүйл болчихоод байгаа шүү дээ. Урд нь 50 тэрбум төгрөг, 100 тэрбум төгрөг миний мэдэхийн тавьж байсан бол одоо бол их наяд төгрөг рүү орчихсон, 900 гаруй тэрбум төгрөг жишээ нь юу руу ороод юу билээ, Хүнсний хувьсгал дээр 900 гаруй тэрбум төгрөг байсан байх, 1 их наяд руу орчихсон билүү, тийм мөнгөн төлбөрүүд гарч ирж байгаа болохоор үнэхээр эдийн засгийнхаа уялдаад, эдийн засагтай уялдаад том хөтөлбөрөө хэрэгжүүлсэн нь илүү харагдаад байгаа болохоор энэ ЖДҮ-лэлийн газар маань байх уу, үгүй юү гэдэг асуудал яригдаж байгаа. Тэгээд цаашдаа заавал энийг устаж үгүй болгоод яах вэ, энэ чигээр нь дэмжлэг хийе. Магадгүй энэ газраар дамжуулж тэр нөгөө том хөтөлбөрүүд маань явдаг ч болгох ёстой юм уу иймэрхүү бодлого барьсан нь зүйтэй юм уу л гэж харж байгаа.

Б.Бейсен: Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Бат-Эрдэнэ даргаа би ийм л юм асуугаад байгаа юм л даа. Яг энэ ЖДҮ-лэлийг хөгжүүлэх сангийн асуудлыг ингээд яриад эхлэхээр энд тэр юу ороод ирлээ гээд байна шүү дээ халамжийн бодлого, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гээд Аубакир сайдын ажлын юунаас энд ороод ирчхэж байгаа байхгүй юу хамаарах хүрээнээс. Бизнесийн зөвлөх үйлчилгээнүүдийн төвүүдийг өргөжүүлэх гээд. Тэр үйлдвэр, технологийн парк байгуулна гээд ороод ирэхээр энэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам. Тэгэхээр чинь энэ өөрөө тусдаа хуультай тийм ээ, та мэдэж байгаа шүү дээ Үйлдвэр технологийн эрх зүйн байдлын тухай хууль гээд. Энэ яагаад энд заавал татан оролцуулаад ингээд хамаатуулаад оруулаад ирэв л гээд.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ дарга хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Анх ЖДҮ сан байгуулагдаад зорилго нь ер нь сая түрүүн хэлсэн шүү дээ ажлын байр нэмэгдүүлэе гэдэг л ийм зорилго агуулчихсан юм, тийм. Тэгэхээр яг одоо хэдийгээр ХААЯ-ны дэргэд байгаа ч гэсэн ажлын байр нэмэгдүүлэх хүрээнд бүх л салбарыг дэмжих, ерөөсөө л хүн ардын ЖДҮ-лэлийг дэмжих боломж хангая гэдэг чиглэлээр явчихсан юм. Яг бүр одоо жишээ нь ХАА-н тийм чиглэлээр, тийм чиглэлээр эд нар гэсэн бүүр ийм тодорхой зүйл байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр миний яриад байгаа нь ингэж байлгах юм уу, эсвэл яг тодорхой том хөтөлбөрүүдээ жил, жил гаргаж ирээд байгаа энэ том хөтөлбөрүүдээ эднийхээр дамжуулаад явуулах юм уу гээд. Тийм болохоор таны харж байгаа өнцөг нь нөгөө янз янзын ийшээ тийшээгээ хамаагүй өгөөд байгаа юм шиг, эд нар хариуцлагагүй гаргаж яваад байгаа юм шиг болчихоод байгаа юм л даа. Гэтэл яг газар дээрээ үзэхэд сайдын чиглэл өгсний дагуу л эд нар маань зээл олгож байгаа юм. Тэгэхээр бид магадгүй тэр нөгөө дүрэм журам хуульдаа бүүр заагаад зөвхөн жижиг, дунд.../минут дуусав/

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: 2019 оноос хойш ажиллаж байгаа ЖДҮ-лэлийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр ажлын хэсэгт миний бие орж ажилласан. Хэд хэдэн саналуудаа энд хэлье гэж бодож байна. Гишүүдийн зарим саналтай санал нэг байгаа. Суурь асуудлаа ер нь бид жоохон тойроод яваад байгаа асуудлууд байгаа. Ялангуяа ЖДҮ-лэлийг дэмжих сангийн үйл ажиллагаа ХААЯ-ан дээр байгаатай холбогдолтой зөвхөн ХАА-н чиглэлийн асуудлуудыг хөндөж байна уу гэдэг ийм өнцгүүд яах вэ явж байгаа. Монгол Улсад өнөөдөр тодорхой хэмжээнд төрөөс 3 төрлийн зээлийг иргэддээ олгож байна гэж би хараад байгаа юм. Хамгийн эхнийх нь өрхийн буюу бичил бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлийн хөдөлмөр халамж дээр байгаа зээлүүд байгаа. 2 дахь нь энэ ЖДҮ-лэлийг дэмжих чиглэлийн арай банкнаас урт хугацаатай, бага хүүтэй, арай санхүүжилтийн хувьд ийм бага боломжтой ийм зээлүүд байна. 3 дахь нь арилжааны банкнуудаар дамжуулан олгож байгаа томоохон энэ төсөл, хөтөлбөрүүдийг дэмжих чиглэлийн зээлүүд гээд 3 чиглэлийн энэ үндсэндээ зээлүүдийг олгож байна.

ЖДҮ-лэлийг дэмжих чиглэлийн энэ зээлийн энэ хувилбар цаашдаа байнга үргэлжлээд явах ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа. Энэ хүрээндээ харин тодорхой суурь асуудлуудыг шийдэх хүрээнд бүтэц, зохион байгуулалт дээр, уул нь нөгөө нэг иргэдэд ХААЯ-н дээрээ байна уу, хөдөлмөр халамж дээрээ байна уу хаанаа байх нь хамаагүй байгаад байгаа юм. Юм хийж бүтээе гэж бодож байгаа иргэн төрийн аль нэг үйл ажиллагаа юман дээр ингээд очиход бид бөмбөг хөөлгөхгүйгээр, тухайн хүний нөхцөл байдал, боломжийг нь бид судлаад, танд энэ төрлийн зээлийн үйл ажиллагаа юм нь боломжтой юм байна гэж нөгөө хүнийхээ хийж бүтээе гэж байгаа энэ зүйлүүдийг нь бид дэмжих ийм хандлагын, зохион байгуулалтын ийм өөрчлөлтийг үндсэндээ хийх зайлшгүй хэрэгцээтэй байгаа юм гэдгийг би урьд нь нэлээн олон удаа уламжилж байсан. Энэ чиглэлийн юмыг нэлээн цаашдаа анхаарах ёстой юм байна лээ гэдгийг би цохоод хэлчихье.

Байнгын хорооны гишүүдийн маань анхаарах ёстой зүйлүүд байгаа. 2020 оноос хойш тодорхой хэмжээнд ямар нэгэн санхүүжилтгүйгээр, төрөөс санхүүжилтгүйгээр өмнөх олгосон зээлээ үндсэндээ буцаан олгох байдлаар явж байгаа. Яг үнэндээ Эрдэнэсайхан даргын хувьд үндсэндээ өр авлага барагдуулах ажил бараг дийлэнх хэсэгтээ хийж байгаа байх. Энэ чиглэлээрээ ч нэлээн идэвхтэй, сайн ажиллаж байгаа. Цаашдаа ерөөсөө энэ ЖДҮ-лэлийн үйл ажиллагааг бид болино, болихгүй гэдэг тухай ярих нь утгагүй. Ийм бага хүүтэй тодорхой хэмжээнд явах энэ хөтөлбөр жилээс жилд хүмүүс хамрагдах хүсэлт нь нэмэгдсээр л байгаа. Тийм учраас эхний асуулт нь энэ бид нийт хүсэлтийнхээ хэчнээн хувьд нь зээл олгож байна вэ гэдгийг нь бүгдээрээ нэг харах хэрэгтэй байгаа. Жишээлбэл сүүлийн 2, 3 жилийн хугацаанд хэчнээн ААН хүсэлт өгөөд, хэчнээн нь зээлээ авсан бэ гэдэг дээр бид дүгнэлт хийх ёстой. Эндээс бидний цар хүрээ, энэ хэрэгцээ шаардлага нь тодорхой харагдана. Дараа нь тодруулчихъя.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 6 номер.

Я.Эрдэнэсайхан: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Ганхүлэг гишүүн маань салбарт ажиллаад дэд сайд хийж байсан салбарын асуудлуудыг маш сайн ойлгож байгаа учраас нэлээн асууж байх шиг байна. Ер нь 2019 онд ЖДҮ, үйлчилгээг дэмжих тухай хуулийг батлахдаа иргэн байхгүй болгоод, гол зорилго нь ААН

байгуул, татварын бааз суурь нэмэгдүүлье. Иргэнээрээ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ч зээл аваад, ЖДҮХС-гаас ч зээл аваад байдаг тэр өмнөх алдааг засах ийм зорилгоор иргэн байхгүй болсон. Тийм учраас ажлын байр бий болгох, хадгалах гэдэг Монгол Улсын ЗГ-ын бодлого. Энэ дотроо иргэнтэй холбоотой хэсэг нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд, ААН-үүд ажлын байрыг олноор бий болгох, хадгалах асуудал нь энэ ЖДҮ-ийн асуудалдаа ингээд ороод явж байгаа.

Бид энэ хуулийг хийж байхдаа судалж үзэж байсан. Ингэхэд дэлхийн 40 гаруй улсад, 40 улсын судалгаа хийгээд үзэхэд 39-д нь яг энэ ЖДҮ-ээрээ, үйлдвэрээ энэ арилжааны банкнаас хөнгөлөлттэй ийм зээл олгодог ийм санхүүгийн бүтэц байдаг юм байна лээ. Ингэж байж үйлдвэр хөгждөг. Түүнээс биш арилжааны банкны өндөр хүүтэй зээлээр үйлдвэрлэлийн марж нь давдаггүй учраас үйлдвэрлэл хөгждөггүй. Тийм учраас өнөөдөр Монголд ч гэсэн үйлдвэрлэл яагаад хөгжил сул байгаа юм бэ гэхлээр арилжааны банкны хүүтэй зээлийг аваад үйлдвэрлэгчид өгч чадахгүй байгаа. Худалдаа эрхлэгчдийн хувьд бас боломж байгаа байх. Үйлдвэрлэлийн марж нь өөрөө бага учраас арилжааны банкны зээл аваад авсан үйлдвэрлэл дандаа дампуурч байгаа. Тэгээд ЖДҮХС-гаас зээл аваад овоо хөл дээрээ босоод ирлээ, дахиад танайхаас мөнгө байхгүй болоод бид арилжааны банкнаас авсан чинь ингээд хүнд байдалд орчихлоо гээд ингээд явж байгаа ААН-үүд маш их байгаа.

Тийм учраас хэрвээ Монгол Улс үйлдвэрлэлээ хөгжье, үйлдвэрлэх ёстой гэж бодож байгаа бол тодорхой хугацаанд, тодорхой төсөв зараад ийм бүтцийг сайн дэмжиж өгөөд, үйлдвэрлэлээ хөгжсөний дараа арилжааныхаа шугамаар яв буюу хөл дээрээ тогтсоных нь дараа тэр зах зээлийн зарчмаараа яв гэхгүй бол Монгол Улсын хувьд үйлдвэрлэлийн ялангуяа зах зээлийн үйлдвэрлэлийн туршлага бол 30-хан жилийнх. Тэгээд энэ бол бусад өндөр хөгжилтэй орнуудын үйлдвэрлэлийн процесстой харьцуулахад маш балчир. Тэгээд дэмжлэг байхгүй. Нэг хэсэг сан маань байгаад бас алдаж, оносон. Тэгээд ингээд сүүлийн жилүүдэд ерөөсөө бүх л хэвлэл мэдээлэл, бүх л хурал, чуулган, зөвлөгөөн дээр ЖДҮ муу, ЖДҮ муу гэж ярьдаг болсон. Гэтэл энийг ингээд сайжруулах гээд цаана нь байгаа ажиллаж байгаа залуучуудын хувьд үнэхээр урамгүй байдаг. Төсвөөр дэмжихгүй, ингээд чадан ядан хийж байгаа ажил нь бас үр дүн ингээд нөгөө олон салбараас хамаардаг. Өөрөөр хэлбэл ЖДҮ нь 2,5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой 200 хүртэл ажилтантай, тэгээд уул уурхай, арилжааны банк, банк, санхүү гэдэг юм уу энэнээс бусад салбарууд бараг бүгдээрээ орж байдаг учраас бараг бүх салбар энэ жижиг, дундад орчхоод байдаг. Энэ болгоныг бүгдийг нь дэмжье гэхлээр маш их өргөн санхүүжилт, өргөн бодлого хэрэгтэй болдог.

Өнөөдөр ЖДҮ-ийн асуудлыг зөвхөн ЖДҮ-ийн газартай хамаатуулж бодож боломгүй байгаа юм. Жишээлбэл бүртгэлийн асуудал яригдахад улсын бүртгэл дээр бүртгэдэг компани байгуулъя гэхэд. Муу болохоор ЖДҮ гээд ойлгоод байдаг. Татварын асуудал яригддаг, татварын байгууллага дээр очдог. Гэтэл татварын нэг хувийн асуудал гэдэг юм уу, татварын 9 хувийн буцаалт гээд ярихлаар ЖДҮ-ийнхэн манайд хандаад байдаг. Ингээд маш бага санхүүжилтээр асуудал шийдэх гэж.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж яриулъя.

Я.Эрдэнэсайхан: Нийт хүсэлтийн 17, 8 хувьд нь л олгож байгаа. Өөрөөр хэлбэл 100 хүн төсөл ирүүлэхэд 17, 8 нь авч байгаа гэсэн үг. Гэхдээ энэ нийт Монгол Улсад зээл авахыг хүсээд байгаа ЖДҮ эрхлэгчдийн тоо биш. Нөгөө түрүүний

хэлснээрээ энэ жил ноосонд өгнө, ноолуурт өгөхгүй гэж байгаа учраас ноосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа, явуулахыг зорьж байгаа ААН-үүд л хүсэлт ирүүлж байгаа юм. Бусад нь арьс шир нь байдаг юм уу, мод нь байдаг юм уу, барилга нь байдаг юм уу зээл өгөхгүй. Тэгэхээр ирсэн хүсэлтийн 17, 8 хувийг шийдэж байгаа юм. Нийт арилжааны банкнаас авч байгаа жижиг, дундын салбарт хэрэгтэй байгаа санхүүжилтийн нэг хувь ч хүрэхгүй байгаа. Тэгэхээр энэ нөгөө үйлдвэрлэлээ дэмжиж байгаагийн хувьд маш хангалттай бус дэмжлэг гэсэн үг.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асуулна, нэмье.

М.Ганхүлэг: Тийм, одоо 5 хүн хүсэлт өгөөд, нэг нь үндсэндээ зээлээ авч байна гэж харж болохоор байгаа юм. Дахиад тэр 5 хүнд нь тэгэхдээ бид шалгуур тавьж байгаа гэсэн үг. Ер нь юм хийж бүтээе, өөрсдөө аж ахуй хөгжүүлээд явъя гэж бодож байгаа хүн Монголд олон байгаа. Тэгээд тэдгээр хүмүүсийг үндсэндээ дэмжих чиглэлээр одоо байгаа боломж маань үндсэндээ 5 хүн тутмын нэгд нь энэ ЖДҮ-ийн хүсэлт өгсөн хүмүүстээ олгож байгаа юм гэдгийг бид нэгд анхаарах ёстой байгаа юм.

Хамгийн чухал гол ярих ёстой зүйлүүдийн нэг нь энэ санхүүжилтийн эх үүсвэрийг төсөв харахаар ер нь боломжгүй юм байна гэдгийг бид бүхэн сүүлийн энэ жилүүдийн төсөв дээр ингээд харж байгаа юм. Тэгэхээр энийг буцааж нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой саналуудыг би дахиж нэмээд тодруулъя. Яах вэ ерөнхий заалтууд ажлын хэсгийн дүгнэлт дээр оруулсан. Яг та хэдийн зүгээс төсвийг нэмэгдүүлэх өөр ямар гарц гаргалгаануудыг судалсан, бодсон зүйлүүд байгаа вэ?

Б.Бейсен: 6 номер хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Ганхүлэг гишүүний тодруулгад хариулъя. Үнэхээр ер нь хүсэлт ирүүлсэн ААН-ийн 1/5. Нийт хүсэж байгаагийн 3 хувьд ч хүрэхгүй байгаа. Солонгос, Япон гээд энэ үйлдвэрлэл хөгжчихсөн орнууд судлаад үзэхээр зээл авъя гэж хүссэн, юм хийе бүтээе гэж байгаа хүссэн бараг хүн болгон авч болдог, зээлийн хүү нь бага, хүсэлт өгсөн ААН болгон авдаг, эрсдэл үүсэхэд төр нь даадаг ийм тогтолцоотой юм билээ. Манай хувьд байгаа ганц жижиг сан байгаад байдаг, тэр нь төсөв дээрээс мөнгө төгрөг байхгүй. Тэгээд өмнөхөө чадан ядан төлүүлээд олгож байгаа ийм тохиолдлууд байгаа. Сайдын тушаалаар ажлын хэсэг гараад ЖДҮ, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ингээд энэ ажлын хэсгээс энэ Баялгийн сангийн хөгжлийн сангаас.../минут дуусав/

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Хадгалагдаж байгаа, өсөж үржихгүй байгаа энэ хөгжлийн санд байгаа мөнгийг ЖДҮХС-д зээлүүлээд, тодорхой хугацааны дараа буцааж авна гээд ингээд олговол маш олон ажлын байр бий болох юм байна, энэ сангийн хөрөнгө нэмэгдэх юм байна, олон ААН-үүд шинээр бий болоод, олон татвар төлөгчид нэмэгдэх юм байна гэдэг ийм төслийг бичсэн. Тэгээд бичээд ЗГ-ын гишүүдээс санал аваад, хуучнаар Сангийн яамнаас татгалзсан хариу ирээд, ингээд хуулийн төсөл гацсан байдалтай байгаа. Санхүүжилтийн хувьд.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүний асуулт асууя, тодруулъя.

М.Ганхүлэг: 3 дахь асуулт нь энэ хууль, эрх зүйн орчинтой холбогдолтой асуудлыг гүйцээгээд асуучихъя. ЖДҮ-лэлийг дэмжих тухай хуулийн төсөл дээр зөвхөн санхүүжилтээс гадна өөр зөндөө олон зохицуулалтуудын асуудал яригдсаар байгаа. Яг ямар хэлбэрээр, хэзээ өргөн барих вэ гэдэг дээр яам яаж ажиллаж байна вэ гэдэг дээр тодорхой хариулт авъя. Бусад энэ бизнесийн орчныг сайжруулах чиглэлийн өөр тодорхой хууль, эрх зүйн орчинтой холбогдолтой төслүүдийг энэ Байнгын хороо бусад түвшинд оруулж ирэх ямар төлөвлөгөө байна вэ гэдгийг тодруулаад асуучихъя.

Б.Бейсен: 6 номер хариуля.

Я.Эрдэнэсайхан: Хуулийн төсөл боловсруулагдаад түрүүн хэлсэн байгаа нэлээн олон өөрчлөлтүүд орсон. Жишээлбэл 2,5 тэрбум төгрөгийн жилийн борлуулалтын орлого гэдэг захын 8 нэрийн барааны дэлгүүр ингээд энийг хангахаа больчихлоо. Тийм учраас жинхэнэ ЖДҮ-лэлээ дэмжих гэж байгаа юм бол өөр энэ босгыг нь нэмж өгөөч гээд энэ төсөл дээр жишээлбэл 10 тэрбум болоод ингээд явж байгаа. Мөн татвар, нийгмийн даатгалын ялгамжтай бодлогууд барья гээд нэлээн төслүүд бичигдсэн байгаа боловч ингээд ЗГ дээр Сангийн яамнаас зөвшөөрөхгүйгээр ингээд хүлээгдэж байгаа юм.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. ЖДҮ-лэлийг хөгжүүлнэ гэдэг зөвхөн хөнгөлөлттэй зээл олгох асуудал биш. Энэ тухайн салбарыг тогтвортой хөгжүүлэлтийнхээ зарчимд аваачих агуулга гэж би ойлгож байгаа. Төр өөрөө хулхидаж байна, ЖДҮ-лэл, үйлчилгээ эрхлэгчид маань зээл авч байна, хөнгөлөлттэй зээл авч байна, ямар ч байсан нэг яаж ийж байгаад хэн нэг нь авчхаад байна. Төр нь худалдан авалт хийнэ гээд хууль дээрээ тооцоод оруулчихсан, ийм худалдан авалт хийнэ гээд ирээдүйг нь харуулаад өгчихдөг, тэр чиглэлээр ЖДҮ-лэл, үйлчилгээ эрхлэгчид маань тогтвортой ханган нийлүүлэлт хийхийн тулд үйлдвэрээ байгуулж байгаа, бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж байгаа юм. Зарим техник технологи, инновац шингэсэн бараа, бүтээгдэхүүнүүдийг нэмүү өртөг шингээж, Монгол Улсынхаа нутаг дэвсгэрт үйлдвэрлэж, нийлүүлж байна. Гэтэл төр нь өөрөө энийг зохицуулж байгаа харилцаа хулхидах хэлбэр дээр байгаа юм.

Сая ялангуяа ЖДҮ-лэлийн тухай хуулийн асуудал хөндөгдөж байна. Манай улс худалдааны хуульгүй, хөнгөн үйлдвэрийн хуульгүй, арилжааны хуульгүй. Миний сүүлд сонссоноор арилжааны хууль явж байгаад Хууль зүй, дотоод хэргийн яамнаас буцчихсан сурагтай байна лээ. Тэгээд ингээд нөгөө бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж болоод байна, нийлүүлэлт нь байхгүй. Тэгэхээр мянган зээл аваад, мянган сайхан үйлдвэр байгуулаад, мянган тоног төхөөрөмж авчраад худалдан авагч байхгүй процесс үүсчээд байгаа юм. Гэтэл манайх Бүгд Найрамдах Хятад Ард Улс /БНХАУ/, Оросын Холбооны Улс /ОХУ/ гээд хүн далайтай 2 том улсын дунд оршиж байдаг. Одоо энийгээ яаж нэг ийм тогтвортой тогтолцоонд нь хэдүүлээ оруулах вэ гэдгээ шийдэх цаг хугацаа бол болжээ.

Тэрнээс биш ингээд л нэг ЖДҮ-лэлийг хөгжүүлэх сан гээд гараад ирдэг, сан нь өөрөө ингээд ажиллаад л байдаг чааваас. Эрдэнэсайхан дарга хэчнээн сайхан цагаан залуу байлаа одоо бүүр палийсан хар л хүн болсон байна шүү дээ. Ингэтлээ л зүтгэж байгаа. Тэгээд Эрдэнэсайхан дарга сайн ажиллаж байгаа. Энэ даргын үед аливаа гэмт хэрэгтэй холбоотой асуудлууд үүсээгүй, бүгдийг нь цахимжуулж, тухайн

сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй болгож ажиллаж байгаад талархаж байгаа үнэхээр жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өмнөөс. Энийг 1 дүгээрт шийдэх хэрэгтэй байна.

Энэ тогтолцоо дотор нэг асуудал. Манай Хөвсгөл аймаг Хөх баавгай брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид байдаг. Худалдаалах цэг байхгүй. ЖДҮ үйлдвэрлэгчид, гар урлал үйлдвэрлэгчид гээд жижиг бизнес эрхлэгчид, дунд зэргийн бизнес эрхлэгчид маань худалдаалъя гэхээр худалдаалалт нь өөрөө худалдааны төвөөр дамжуулагдаж явахаар их хэмжээний төлбөр төлөөд байгаа юм. Энийг орон нутаг нь зарим нь дэмжинэ, зарим нь дэмждэггүй. Манай Хөвсгөл аймаг Төмөрбаатар дарга маань сайн дэмжээд явж байгаа. Тэгэхдээ энэ нийтлэг байх ёстой 21 аймагт. Улаанбаатар хотод ч гэсэн. Тэгээд энэ харилцааг та хэд маань бодлогын түвшинд цогцоор нь авч үзэж чадаж байгаа юу? Ер нь яг хаанаа алдаа гараад байна вэ? Зээлээ авчхаад байна, бүтээгдэхүүн үйлдвэрлээд байна, худалдаалж чадаж байна уу?

Б.Бейсен: 6 номер хариулья.

Я.Эрдэнэсайхан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья. Үнэхээр яг үнэн л дээ. Бидний хувьд яг ингээд бага мөнгөөр нэлээн хэл амтай сонгон шалгаруулалт хийдэг учраас нэлээн шат дамжлагатай байдаг. Тэгээд бид түрүүний хэлсэн нөгөө ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгох дээр илүү дэмжээд байгаа гэдэг маань яг Бат-Эрдэнэ гишүүний хэлээд байгаатай адилхан. Бид Оросоос гэдэг юм уу, Хятадаас түүхий эд авчраад Монголд үйлдвэрлэл хийгээд, тэд нартай өрсөлдөж чадахгүй. ХАА-н гаралтай Монголдоо малын гаралтай, газар тариалангийн гаралтай энэ гарч байгаа түүхий эдээ эцсийн бүтээгдэхүүн болгоод, үнэ цэнтэй бүтээгдэхүүнийг олон улсын зах зээл дээр гаргах бол манай хамгийн гол зорилго. Гэхдээ энэндээ хүрэхийн тулд жижиг, дундууд маань дан дангаараа чаддаггүй. Тийм учраас хамтарч гарах хэрэгтэй болдог. Тийм учраас нөгөө зээл олгож байгаа салбар чиглэлээ аль болох энэ ХАА-н гаралтай хаягдаж байгаа энэ арьс шир гэдэг юм уу бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгож гаргах чиглэл рүү чиглэж байгаа.

Үнэхээр үнэн. Одоо яг ингээд Төрийн худалдан авалтын хуульд саяын түрүүн нөгөө бид хуулийн төсөл дээр ажиллаад ингээд төрийн худалдан авалт Тендерийн хууль дээр ингээд өөрчлөлт оруулахаар санал оруулсан. Цахим дэлгүүрт оруул гэдэг, цахим дэлгүүрт юмаа оруулж чадахгүй байна гэдэг гомдлууд маш их ирдэг. Бид Төрийн худалдан авах ажиллагааны газрынхантай нэлээдгүй ажиллаад, нэлээн олон бараа, бүтээгдэхүүнээ цахим дэлгүүр лүү оруулсан. Тэгэхдээ энэ хангалттай биш байгаа юм. Өөрөөр хэлбэл бид араас нь гүйж байж ААН-тэйгээ нийлж байж оруулдаг биш, Төрийн худалдан авах ажиллагааны газар бол бараг өөрснөө хэн байна вэ гээд оруулдаг байх ёстой.

Бид Монгол Улсын Ерөнхийлөгч 2019 онд Ерөнхий сайд байхдаа эх оронч худалдан авалт гэдэг арга хэмжээг хамгийн анх санаачлаад зохион байгуулж байсан, 2 жил тутам хийдэг. Энүүгээр төрийн байгууллагууд ямар ч байсан дотоодын үйлдвэрүүдээсээ худалдаж авах энэ тодорхой механизмыг бий болгосон. Гэхдээ тийм бүүр төгс болж чадаагүй байгаа юм. Нэг талдаа төрийн байгууллагууд юу худалдаж авч байгаа энэ жилийнхээ төлөвлөгөөг танилцуулдаг, нөгөө талдаа хувийн хэвшил хийж байгаа бараа, бүтээгдэхүүнээ танилцуулаад уулзаад, эндээс бид ямар ч байсан тодорхой хэмжээнд төрийн байгууллагууд жилдээ хэдэн тэрбум

төгрөгийн худалдан авалт хийж байна энийг нь хэдийг нь дотоодоосоо авч байна гэдэг тоо баримтыг гаргадаг болчихсон. Тэгэхдээ энийг Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтарч нэлээн шахаж байж гаргаж байгаа. Манайхаас энийг хийх ямар ч потенциал боломж байхгүй.

Тийм учраас энэ цахим дэлгүүр дээр байршуулах асуудал нэлээн яригдаж байгаа. Ингээд саяхан сар гаруйн өмнө шинэ ЗГ тодорхой шийдвэр гаргаад, энэ оёдол, энэ гутал үйлдвэрлэлийн ААН-үүд цахим дэлгүүрт байршуул гэдэг ийм ЗГ-ын тогтоол гаргаад, Төрийн худалдан авах ажиллагааны газарт даалгавар өгсөн. Энэний дагуу ХХААХҮЯ Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтраад ажиллаж байгаа. Үнэхээр нэг талдаа зээл аваад, худалдан авалтыг нь бид төсөл учраас яаж борлуулалт хийхийг нь төсөл дээр шалгадаг. Яг амьдрал дээр тэр маань тодорхой хувиар яг үнэнээрээ явж чадаж байна уу, үгүй юу гэдгийг нь дараа нь хянадаг. Энд алдаатай юмнууд гардаг. Жишээлбэл ингэж борлуулна гэж хэлчхээд, тэр төслөөсөө өөрчлөгддөг юмнууд байдаг. Гэхдээ бид төслийг сонгон шалгаруулахдаа тэр төслийг нь уншиж байгаа учраас тэр ямар бүтээгдэхүүн үйлдвэрлээд, хэдийг, ямар үнэтэй зараад, ямар ашиг олоод, тэрнээсээ зээлдээ хэдийг төлөх юм, өөрөө аж ахуйгаа яаж авч явах юм гэдгийг нь төсөл дээр нь бүрэн судалгаа хийж байж, тэр шалгаруулалтыг хийдэг.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Яах вэ 1 дүгээрт ингээд нөгөө сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу явуулна гээд бүгдийг нь тэгш нөхцөл дээр тавьчихдаг. Энэ нэг талдаа жоохон өрөөсгөл болж байгаа юм. Яагаад гэхлээр жишээлбэл БНСУ-ын И Март 157 ширхэг байдаг байхгүй юу Солонгос улсын нутаг дэвсгэр дээр. Тэндээс нэгэнт худалдан авалтыг нь зөвшөөрөөд, танай бүтээгдэхүүнийг бид авъя гээд ороод ирдэг. Гэтэл тухайн худалдан авалт нийлүүлэх хүн нь бэлэн, худалдан авагч нь Солонгос улсын зах зээлд бэлэн байгаад байдаг. Гэтэл зээл авъя гээд орохоор өгдөггүй, ижил түвшинд авч үздэг ийм юм бас байна. Тэгэхээр бид ийм татварын ялгамжтай бодлого гэдэг шиг энэ аль, аль талдаа юмнуудаа уул нь хардаг байвал их зөв зүйтэй л байна. Тэгээд энэ гадаадаас жишээлбэл худалдан авалт нь тодорхой болчихсон, маш ойлгомжтой баталгаа гарчихсан ийм худалдан авалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид дээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлдэг вэ?

Б.Бейсен: 6 номер хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Бат-Эрдэнэ гишүүний тодруулгад нэмж хариулъя. Үнэхээр яг тийм байгаа. Одоо дахиад л нөгөө төсөв мөнгөтэйгөө холбоод ярих гээд байна. Бүх л юм яг төсөвтэй холбогдож байгаа учраас. Бид томоохон, том гэж хэлэх үү, дунд ААН-үүдээ дэмжиж чадахгүй байгаа. Өөрөөр хэлбэл экспортод гаргах гээд юм нь бэлэн байгаад байдаг, И март авъя гээд байдаг. Гэтэл нөгөө өмнө олгосон зээлээсээ жилдээ 34, 5-хан тэрбум төгрөгийг төвлөрүүлж байгаа. Энийгээ 2,5 тэрбум төгрөг нэг ААН-д өгнө гэвэл 10 ААН-д өгөөд л дуусчихна. Тэгэхээр бид зээлийн хүртээмжээ бодоод илүү олон ажлын байр бий болгох, бичил тал руугаа дэмжээд хуулиараа 300-гаа хүртэлхийг нь сангаасаа шууд олгоод яваад байгаа юм. 300-аас 2,5 тэрбум төгрөг олгох арилжааны банкаар дамжуулах энэ хуулийн зохицуулалттай хэсэг дээрээ төсвөөс болоод нэг ч төгрөг өгч чадахгүй байгаа. Тэгэхээр яг.../минут дуусав/

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн 2 асуусан уу? 2 асуучихсан байна Бат-Эрдэнэ гишүүн. Дараа үг байгаа юм байна. 1 асуусан уу, Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгээд ер нь хэдүүлээ юу яая энэ ХХААХҮ-ийн дэд сайдаар манай Ганхүлэг гишүүн ажиллаж байсан энэ туршлага өндөр. Энэ яамыг хүлээлгүйгээр хэдүүлээ энэ хуулийг нь Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө өргөн бариад, цэгцлээд явъя. Тэгэхгүй бол энэ чинь яаман дээр очихоор яамнуудын санал аваад л, хэн нэгнийх нь эрх ашиг нь хангагдахгүй болохоор буцаад л ингээд байгаа. Тэгээд бүрэн эрх бидэнд байна, манай Улсын Их Хурлын дэд дарга Бат-Эрдэнэ ах маань байна, манай Мандхай гишүүн байна, манай Мөнхбаясгалан гишүүн байна, Тэмүүлэн гишүүн маань байна ингээд. Ганхүлэг гишүүн энийг санаачлаад хэдүүлээ хуулиа нэлээн сайн өөрсдөө манлайллаа аваад явъя гэдэг ийм бодит саналыг би гишүүддээ тавимаар байна. Манай Замира эгч байна, Алтаншагай гишүүн маань байна. Хэдүүлээ нийлж байгаад энэ хүнс, хөдөө юу ЖДҮ-лэлийг дэмжих тухай хуулийг ер нь явуулъя. Тэгэхгүй бол ингээд нөгөө ЗГ гэдэг юм уу, эсвэл тогтоол тогтоомж, эрх зүйн актууд гээд ингэсээр байгаад энэ чинь бүр замраад алга боллоо. Дэмжиж байгаа ч юм алга яг үнэндээ.

Б.Бейсен: Энэ ажлын хэсгийн дүгнэлттэй танилцсан. ЖДҮ-ийн зээл гээд нэлээн олон тэрбум зээл олгосон. Зарим нь зүгээр нэг хүлэмжид авчихсан, зүгээр услалт тийм юмаар авчихсан. Тэгэхээр энэ асуудал дээр нэлээн анхаарахгүй бол болохгүй нь. Яг малын түүхий эд боловсруулах юун дээр хэчнээн тэрбум төгрөгийн ЖДҮ-д зээл олгосон бэ, одоо боссон үйлдвэр байна уу 1 дүгээрт? 2 дугаарт энэ хүнсний хувьсгалын хүрээнд яг олгогдсон зээл хүнсний ногоо боловсруулах үйлдвэрийн ч юм уу яг боссон үйлдвэр хэд байна 1 дүгээрт асууя?

2 дахь асуудал ЖДҮ-ээс зээл авчхаад, хэвийн ажиллаад зээлээ төлж явж байгаа компани хэд байна вэ, хэдэн тэрбумын зээл авсан юм бэ тэд? 2 дугаарт төлөх чадваргүй шүүхийн шат, хууль шүүхийн шатанд явж байгаа компани хэд байна вэ, тэдэнд хэдэн зуун тэрбум төгрөгийн зээл байна вэ? Дараагийнх нь найдваргүй зээл гэж байна ЖДҮ-ээс авсан. Урьд 4 жил бас бид ярьж байсан одоо эзэн нь олдохгүй байгаа тийм хэчнээн компани байна вэ, энэ талаар тодорхой мэдээлэл авъя? Дараагийнх нь давхардуулан зээл жил болгон ЖДҮ-ээс зээл авсан юм байна уу ер нь?

Нөгөө талаар аймгууд тодорхой хэмжээний орон нутаг хөгжүүлэх сан аймгийн төсвөөс 40 хувь гээд сая Бат-Эрдэнэ дарга ярьж байна. Уг нь аймгууд тодорхой хэмжээний ЖДҮ-д төсөв тавьж байгаа, дээрээс нь яам төсөв тавина гээд ийм асуудал ярьж байгаа. Жил болгон ер нь ЖДҮ-ийн эргэн төлөлт хэд байна, энэ жил 90 хэдэн тэрбум болсон уу? Анх ноднин бид хавар асуухад эргэн төлөлт нь 47 тэрбум билүү, 67 тэрбум байсан шиг санагдаад байх юм. Энэ талаар тодорхой асууя. 6 номер.

Я.Эрдэнэсайхан: ЖДҮХС-гаас зээл аваад амжилттай явж байгаа маш олон компани байгаа. Орон нутагт очоод ажиллавал ер нь арай гайгүй юм хийж байгаа ААН-үүд бүгд ЖДҮ хөгжүүлэх сангаас зээл авч байгаа. Гэхдээ бид өөрсдөө ч очоод асуудаг та нар яагаад ингээд зээл авч байгаагаа ил тод мэдэгддэггүй юм бэ гэхлээр нөгөө муу нэртэй ЖДҮ-ээс болоод хэлж чаддаггүй юм гээд. Ингээд сая Дархан дээр Монгол Улсын Ерөнхий сайд ажилласан. Тэнд нэг ААН-тэй танилцаж байгааг нь харсан, манай зээлдэгч, 2 жилийн өмнө зээлээ өгөөд амжилттай дууссан. Гэхдээ тэрийгээ дурдаагүй. Би өөрөө араас нь утасдаад та манайхаас зээл авчхаад яагаад

ингээд амжилттай явж байгаагаа хэлдэггүй юм бэ гэхлээр үгүй ингээд ЖДҮ чинь муу нэртэй болохоор гээд. Тэгээд бодит байдал дээр яг ийм байгаа.

Нийтдээ 9200 зээлдэгчид 1,1 их наяд төгрөгийн зээлийг өгсөн. Өнөөдрийн байдлаар 250 гаруй чанаргүй зээл байгаа. 84 хувь нь зээлээ бүрэн төлөөд дуусчихсан. Тэгэхээр нийт зээлийн 2,7, 8 хувь нь чанаргүй зээлийн ангилалд орж байгаа. Энэ бол арилжааны банкны тавьдаг шалгуураас ч хангалттай эргэн төлөлтөө төлүүлсэн байна гэж. Энэ 250 гаруйнх нь 70 гаруй хувь нь шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр аль хэдийн шүүхийн шийдвэр нь гараад, шийдвэр гүйцэтгэлээр ажиллагаа нь хийгдээд явж байгаа ийм зээлдэгчид байгаа. Өөрөөр хэлбэл бид өнгөрсөн хугацаанд өмнө олгогдсон зээлүүдийг араас нь хөөцөлдөөд, ямар ч байсан шүүхийн шийдвэрүүдийг нь гаргуулсан. Шүүхийн шийдвэр гаргахад бараг 3, 4 жил болж байгаа. Шийдвэр гүйцэтгэл дээр дахиад 3, 4 жил болдог, бүүр шийдвэр гүйцэтгэл дээр 10 жил болсон хэрэг ч байна. Хүн нь байдаг, гүйцэтгэлийг нь хангуулдаггүй. Тэгээд бид олон удаа шийдвэр гүйцэтгэлтэй уулздаг, бичиг явуулдаг. Ингээд үр дүн гарахгүй.

Тэгэхээр өөрөөр хэлбэл эргэн төлөлтийг сайжруулахын тулд өөрийн байгаа хэмжээндээ ажиллаад байдаг. Гэтэл бусад байгууллагуудаас хамаараад энэ эргэн төлөлт нь гүйцэд орж ирэхгүй ийм байгаад байгаа юм. Орон нутгийн улсын ЖДҮХС-ийн эх үүсвэр бол хуулиараа улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, өмнөх эргэн төлөлт гэсэн ийм эх үүсвэрүүдээс бүрддэг. Улсын төсвөөс мөнгө өгөхгүй байгааг хангалттай хэлж байгаа. Гадаадын зээл, тусламж бол мэдээж ийм нэртэй санд орж ирэхгүй. Тэгэхээр бид эх үүсвэрээ яаж нэмэгдүүлэх вэ гэж тооцоолж байгаад, орон нутгаасаа төсөв хөрөнгө хуваарилдаг аймгуудад энэ төсөв хөрөнгөө хуваарилъя гэдэг ийм шийдвэрийг гаргаад, 2021 оноос аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, Иргэдийн хурлын даргад тогтмол жил болгон бичиг явуулж байгаа юм.

Ингээд хамгийн анх Өмнөговь аймаг, Сүхбаатар аймаг гээд 2 аймаг орон нутгийнхаа төсөвт мөнгө тавиад, аймгийнхаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд дэмжиж эхэлж байсан бол энэ жил 11 аймаг болсон байна. Энэний үр дүнг ойлгоод, аймгууд орон нутгийнхаа төсөв дээр мөнгө хуваарилаад, тэр аймаг дээр нь дэмжлэг үзүүлээд явж байгаа. Улаанбаатар хотын ЖДҮ эрхлэгчид энэ дээр маш их гомдол тавьж байгаа. Харамсалтай нь аймаг, нийслэлийн, нийслэл, дүүргийн Иргэдийн хурал, Засаг даргаас ийм санаачилга гарахгүй буюу ЖДҮ эрхлэгчдээ дэмжих ийм санал гарахгүй, санаачилга гарахгүй байгаа учраас хуваарилалт хийгдэхгүй явж байгаа. Энэ жилийн хувьд эргэн төлөлтөөс 34,9 тэрбум төгрөг орно гэж бид төлөвлөж байгаа. Орон нутгаас 7,2 тэрбум төгрөг гээд нийтдээ 42 тэрбум төгрөгийг ААН-үүдэд зээл болгох, зээл өгөхөөр ажиллаж байгаа. Энэ дээр Монгол Улсын ЗГ, ХХААХҮ-ийн сайдын тушаал гаргаад, сонгон шалгаруулалтыг богино хугацаанд хий гэдэг.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж хариулъя, 6 номер.

Я.Эрдэнэсайхан: Сонгон шалгаруулалтыг богино хугацаанд хий гэдэг даалгавар өгсөн. Үүний дагуу 20 хоногийн дотор бид сонгон шалгаруулалтыг хийж байгаа. ААН-үүдээс энэ сонгон шалгаруулалт удаан байна, зээлээ авах гэж уддаг гэдэг ийм мэр сэр гомдол ирдэг. Бид хамгийн хурдандаа арилжааны банк дор хаяж 3, 4 сар судалдаг шүү дээ. Манайх 14 хоногоос 20 хоногийн дотор ч зээл, төслийг нь бүрэн хүлээж авснаас хойш олгосон процесс тохиолдол байгаа. Өөрөөр хэлбэл бид

дунджаар 20 хоногоос 25 хоногийн дотор зээлийг нь олгочихдог. Өөрөө сонгон шалгаруулалтдаа зарлаад, нөгөө барьцаа хөрөнгөө авчирч өгөхгүйгээр яваад алга болчихдог юм. Ингээд хэдэн сар болчихоод, дараа нь нөгөө энэ чинь тухайн жилдээ хүчинтэй учраас 25 онд сонгон шалгаруулсан сонгон шалгаруулалт 26 он гарангуут төсөв нь хураагдчихдаг учраас байхгүй болонгуут тэр ААН-үүд удаан байна гэдэг гомдол тавьдаг. Бид ийм хэд хэдэн тохиолдлыг гаргаж ирээд, тухайн ААН-д нь утсаар болон албан бичгээр мэдэгдэж байснаараа ингээд.../минут дуусав/

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасалъя. Мандхай гишүүн асуулт, үг хэлье.

М.Мандхай: Ер нь яах вэ ЖДҮ-лэлийн сангийн олгож байгаа зээл яг хөдөлмөр эрхлэлтийн сантай ер нь ямар ч ялгаагүй болчихсон. Нийгмийн хамгааллын ийм шинж давамгайл болчихсон. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан чинь ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, малчдад хүртэл, тариаланчдад хүртэл зээл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээл олгож байгаа. Энэнээс ялгагдах хэрэгтэй гэж харж байгаа юм. Ингээд энэ жил 40 гаран тэрбум төгрөг энэ чинь их мөнгө шүү дээ. Тэгэхээр бид сангийн мөнгө бага байгаа гэхээсээ илүүтэй илүү чанарт суурилсан ийм зээлийг олгодог болгомоор байгаа юм. Жишээлбэл энэ хөдөлмөр эрхлэлтийн сан өөрөө нийгмийн хамгааллын шинж давамгайл бол ЖДҮ-лэлийн сан өөрөө эдийн засагт ЖДҮ-лэлийн тэр хувь нэмрийн оролцоо хэдэн хувь байх юм, үйлдвэрлэлийг яаж хөгжүүлэх юм, жижиг, дунд бизнесүүдийг яаж бойжуулах юм, чадавхжуулах юм, ажлын байрыг яаж бий болгох юм, гэхдээ ажлын байр дотроо бид зохистой ямар ажлын байрыг нэмэгдүүлэх юм, нийгмийн баталгааг нь яаж бий болгох юм гээд энэний цаана Бат-Эрдэнэ даргын гишүүний хэлж байгаа агуулга дээр нь бид төвлөрөх хэрэгтэй цаг болсон байна.

Тэгэхгүй бол Эрдэнэсайхан даргаа таны ярьж байгаа асуудал болгон чинь ерөөсөө яг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ялгагдахгүй ийм асуудал яриад байгаа юм. Тэгэхээр бид үндсэн гол чиг үүрэг өөрөө зээлээсээ арай өөр үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бизнесийн өсөлтийг бий болгоё, тухайн ЖДҮ-лэлийн өсөлтийг нэмэгдүүлж чадавхжуулъя гэсэн энэ чиглэл рүүгээ илүү түлхүү анхаардаг болоод явбал 40 гаран тэрбум төгрөг байсан ч бид чанартай ийм ЖДҮ-лэлийг нэмэгдүүлж чадвал таны төсөв нэмэгдэх бүрэн боломж, сангийн төсөв нэмэгдэх бүрэн боломж бий болох юм гэдэг дээр хэлмээр байна.

Б.Бейсен: Алтаншагай гишүүн үг хэлье.

Н.Алтаншагай: ЖДҮ маань ер нь иргэдэд нэлээн хүлээлттэй байсан, одоо ч ерөнхийдөө унтарчихсан даа, байхгүй болсон. ЖДҮ-ийн тэр зээл нь хаагуураа ч явдаг юм, тэгээд энэ нийслэл, дүүргийн хэмжээнд байгаа энэ ЖДҮ-ийн байгууллагуудад яг тэр санхүүгийн эх үүсвэр, дэмжлэг бодитоор очдоггүй, иргэд нь тэр зээлээ авч чаддаггүй л байх. Тэгээд дүүргийн Засаг дарга байхад нэг хэдэн төгрөг тавиад өгөөч урсгал зардал дээр гээд л нэг иймэрхүү ЖДҮ нь тийм л юм байсан. Тэгээд цагаан сар болдог, наадам болдог тэр үеэр нэг эсгий, давсаар хийсэн юм гаргаад л. Дүүргийн ЖДҮ бол яг өнгө төрх нь яг ийм байгаа шүү. Энд ямар нэгэн байдлаар хүнийг гоочлох, харлуулах, энэ байгууллагыг ийш тийш нь дээш, доош нь хийж байгаа асуудал биш. Яг бодит байгаа үнэн байдал энэ. Тэгээд цагаан сар болохоор Амар байна уу гээд нэг нийслэлийн ЖДҮ үзэсгэлэн гаргадаг, баахан нэг дээл хийдэг нөхдүүд аваачаад л тавьчихсан.

Тэгээд экспортод гаргаж байгаа ийм ЖДҮ-ийн гэсэн яг бүтээгдэхүүн үнэндээ бараг л олж хараагүй. Тэгээд түрүүн ч бас хэлж байх шиг л байна. Ажлын хэсгийн дүгнэлтүүд дээр байна. Санхүүгийн эх үүсвэр дутмаг, бодлогын маш олон алдаатай юмнууд бий, уялдаж чадаагүй юмнууд ч маш их байх шиг байгаа юм. Тэгээд энийгээ засаж сайжруулах, эргэж энэ яг бодит дэмжлэгээ авах хэмжээний түвшин рүү орж, яг энэ хариуцсан салбар сайд нь ч гэсэн энэ дээр онцгойлон анхаарч, дахиж нэг бодлогын түвшинд анхаарлын төвд оруулж ирэхгүй бол ингээд ЖДҮ гэхээр нээрээ бараг л хүмүүс цэрвээд байдаг юм шиг, худлаа яриад нэг зээл авчихсан юм шиг, ЖДҮ-ээс зээл авсан нөхдүүд нь эргээд төлөөгүй ч юм шиг яг нэг ийм мэдрэмжтэй болчихсон. Дарга нар нь хуваагаад авчихдаг юм гэсэн нэг ийм л яриа иргэдийн дунд байж байдаг. Яах вэ ажил хийж байгаа хүмүүст олон бэрхшээл байгаа байх. Гэлээ гэхдээ л энийг даван туулж, эргэж бодлогын түвшинд оруулж ирж, илүү сайн реформ хийж, яаж энэ хууль, эрх зүйн орчныг нь сайжруулах юм, санхүүг нь сайжруулах юм. Энэ дүгнэлт нэлээн ажлын хэсэг чамбай ажиллаж, маш олон энэ санал, дүгнэлтүүдийг гаргасан байна.

Энэ бодлогын тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх, санхүүжилт, татвар, эрх зүйн орчин гээд. Энэ дээрээ яг энэ хүний нөөцийн гээд байж байгаа, ЖДҮ маань яг хөдөө орон нутагт яг ямар байгаа юм бэ, энэ дээрээ нэг онцгойлон анхааръя. Энэ дээр ажлын хэсгийнхэн маань нийслэлийн 9 дүүргийн бизнес эрхлэгчдийн төлөөлөлтэй уулзсан л гэж байгаа юм. Яг тэр аймаг дээр, сумд ямар байгаа юм, хоршоон дээр ямар байгаа юм. Энийгээ нэгтгэсэн нэг ийм томоохон бодлогын шинэчлэлт хийхгүй л бол энэ чигээрээ явбал ингээд л өдрөөс өдөрт, жилээс жилд л хойшоо суух магадлалтай байна гэж харж байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Бодлогын шинэчлэл хэрэгтэй юм шиг харагдаад байгаа юм яг ний нуугүй хэлэхэд. Яагаад гэхлээр 1 дүгээрт малтай газар манай Хөвсгөл аймаг Монгол Улсын хэмжээнд нэг номерын малтай газар. Гэтэл малгүй газрын иргэдэд малын түүхий эдээр үйлдвэрлэх гэж байгаа бараа, бүтээгдэхүүний ЖДҮ-гийн зээлийг малгүй газрын иргэдэд нь өгөөд байгаа байхгүй юу. Малтай газрынх нь авч чадахгүй. Тэгээд энд асуудал үүсээд байгаа нэг.

Нөгөөдөх нь бид ер нь сая Мандхай гишүүний хэлдэг яг үнэн байхгүй юу. Энэ чинь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээл юм уу, ЖДҮ-лэл, үйлчилгээ буюу эдийн засгийг дэмжих зээл юм уу энэ ерөөсөө ялгамжгүй яваад байна. Зээлийн хүсэлт өгсөн болгоныг үндсэн ерөнхий шалгуур тавьчихсан, тэрүүгээр нь зээлийн олголт нь яваад байгаа байхгүй юу. Гэтэл би сая хэлсэн шүү дээ гадагшаа Монгол Улс ямар бараа, бүтээгдэхүүн экспортлох боломжтой юм, Монголын зах зээл нэг тусдаа. Жишээлбэл 987 мянга орчим өрх байх шиг байна Монгол Улсад. 987 мянган өрхөд зориулсан үйлдвэрлэл нэг тусдаа, гэтэл 1,4 тэрбум хүнтэй зах зээлд зориулсан үйлдвэрлэл дахиад тусдаа байгаа байхгүй юу. Гаднаас валют орж ирэх гээд байдаг, гэтэл бид дотооддоо төгрөгөөр арилжаа явагдаад байдаг.

Тэгэхээр энэ гаднаас худалдан авалт хүсэж байгаа малын түүхий эд, эко бүтээгдэхүүнүүд, хүнсний тодорхой хэмжээний бүтээгдэхүүнүүд гэдэг ч юм уу ингээд ялгамжтай бодлого гаргахгүй бол тэгшитгэсэн хэлбэр дээр бүгдэд нь нөгөө эхийг нь эцээж тугалыг нь тураахгүй гэдэг хэлбэр дээр зээл олголтүүд яваад байхаар зээл аваад байна уу аваад байна, үр дүн гарч байна уу гэхээр багахан хэмжээний зээл

авсан хүмүүс дээр л эргэлт бий болоод, өөрөө өөрсдийгөө санхүүжүүлэх орлогын эх үүсвэрээ баталгаатай болгох процессууд яваад байдаг. Яг улс эх орны эдийн засагт ямар хэмжээний эргэлт бий болсон юм, хэдий хэмжээгээр улсын эдийн засгийн эргэлт өссөн юм, хэдий хэмжээний энэ жил жишээлбэл өгсөн жижиг үйлдвэрлэл эрхлэгчид өгсөн зээлийн үр дүн дунд хэмжээнд, дунд нь хэдий хэмжээнд том хэмжээний бизнес болсон юм, яаж өргөжиж байгаа юм, хэдэн салбар байгуулсан юм. Хүний нөөц гээд байгаа юм. Гэтэл хүний нөөц чинь өөрөө чадавхжилтай, чадамжтай холбоотой асуудал байхгүй юу. Гэтэл хүний нөөцтэй гээд 5 хүнтэй гэсэн нэг үйлдвэрт өгөөд байдаг. Гэтэл үнэхээр чадамжтай 3 хүнтэй үйлдвэр нь зээлээ авч чадахгүй байгаад байдаг.

Тэгэхээр миний хэлэх гээд байгаа гол санаа бол бодлогын түвшин дээр хэдүүлээ энэ ЖДҮ-лэл, үйлчилгээтэй холбоотой асуудал дээр орох цаг нь бол одоо яг Эрдэнэсайхан дарга болсон, болсон. Бизнесээ эрэмбэлмээр байна хэдүүлээ. Экспортод гаргах боломжтой бизнесүүдээ түрүүлээд дэмжмээр байна. Тэнд нэгэнт баталгаатай Солонгос улс байдаг юм уу, эсвэл Хятад улс байдаг юм уу, бусад ойр тээвэрлэлт нь боломжтой газар орон нутгууд руу үнэхээр баталгаатай нийлүүлэлт, ханган нийлүүлэлт авъя гэж байгаа ЖДҮ-лэлийнхээ асуудлыг та бүхэн маань нэг номерт тэргүүн зэрэгт тавиад дэмждэг систем рүүгээ ороод өгөөч. Тэгэхгүй болохоор дотооддоо үйлдвэрлээд байна гээд л, үйлдвэрлээд л байна гээд л байна. Та хэд сүүл рүүгээ бараг өр барагдуулах алба шиг тэд нарын араас хөөцөлдсөн бодлого руугаа анхаарсан биш, хэрэгжилт дээрээ бие биеийгээ хөөцөлдсөн хэлбэр лүү яваад цаг хугацаа чинь дуусчхаад байгаа байхгүй юу.

Тийм учраас миний хэлээд байгаа хуулиа яаралтай хэдүүлээ гаргая. Хуульгүйгээс улбаатай тодорхой хэмжээний асуудлууд энд үүсээд байх шиг байна. Тэгэхээр хуулиа яаралтай гаргамаар байна. Хууль дээр эрэмбээ хэдүүлээ зөв зүйтэй тогтоож оруулмаар байна. Эдийн засгийн эргэлтээ бий болгомоор байна, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ялгамжтай шүү гэдэг ялгамжаа хэдүүлээ тодорхойлдог баймаар байна. Тэгэхгүй болохоор хоёулаа л ажлын байрыг нэмэгдүүлэх зээл болчихоод байна. Уул нь нэг нь эдийн засгийг идэвхжүүлэх, эдийн засгийн эргэлтийг бий болгох, доллар оруулж ирэх зээл байхгүй юу нөгөө талдаа бараг. Эдийн засагт том нөлөөтэй зээл.

Б.Бейсен: Гишүүд үг хэлж дууслаа. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

17.00 цаг

Дараагийн асуудалд оръё. Дараагийн асуудалд орохоосоо өмнө нэг зарлалын чанартай Байнгын хорооны гишүүддээ нэг юм дуулгая гэж бодож байна. Энэ Баян-Өлгий аймгийн Алтай сумд үхрийн шүлхий өвчин гарсан, батлагдсан. Энэ нь нэг ховор тохиолдол SAT1 дэд хэвшлийн нийцэлдээ юу, штаммтай (Strain) юм байна. Урд нь А, О хэлбэрийн вирусээр өсгөгдсөн байна. Одоо энэ удаагийнх нь Монголд ер нь вакцин энэ тэр нь байхгүй, шинжилгээг нь бүүр гадаад Герман, Англи руу явуулаад хийлгэж байгаа юм байна. Тийм учраас энэ өнөөдөр Онцгой комисс хуралдаж байгаа, Баян-Өлгий аймгийн Алтай сум, Өлгий, Бугат сумын хөл хорио тогтоочихсон, карантилчихсан байгаа. Энэ ан амьтнаас халддаг тийм урьд нь ОХУ-д Уйгур-Шинжаан, Дундад Азид гарч байсан юм байна. Энэ мал махны экспорт, аялал жуулчлалд нэлээн хүндрэл учраад байгаа. Энэтэй холбоотой Онцгой комисс өнөөдөр хуралдаад яачихвал маргааш, нөгөөдрөөс Байнгын хороо хуралдвал

бүгдээрээ асуудал дээр, энэ төсвийн асуудал байхгүй юм байна, ЗГ-т чиглэл өгөх талын юм гарвал та бүгд зарлал өгөхөд, бэлэн байгаарай гээд хэлье.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай/

Дараагийн асуудалд оръё. Байнгын хорооны тогтоолын төсөл Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 21 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагууд, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдвээр ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын даргад ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д Улсын Их Хурлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд нь хяналт тавих зорилгоор ерөнхий хяналтын сонсголыг явуулна гэж, мөн хуулийн 29.2-т Улсын Их Хурал нь Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу заавал явуулна гэж заасны дагуу дээрх сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулсныг та бүхэнд хүргүүлсэн байгаа юм.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Замира гишүүнээр тасалъя. Мөнхбаясгалан гишүүн асуулт асууж.

Л.Мөнхбаясгалан: Энд л ормоор байна, яах билээ. Энэ Малчны тухай хуулийн хэрэгжилт ерөнхий хяналтын сонсголд ормоор байна. Юу гэх билээ, саналаа өгч байна гэх билүү. Саналтай байна.

Б.Бейсен: Дараагийн асуудал. Замира гишүүн асуулт асууж, үг хэлье. Асуулт, үг цуг байгаа шүү.

С.Замира: Баярлалаа. Энэ Малчдын тухай хуулийн хэрэгжилтэд ерөнхий хяналтын сонсгол явуулах энэ ажлын хэсэгт орж ажилламаар байна. Тийм.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнийг нэмье асуулт асуухаар. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүний микрофон.

Б.Бат-Эрдэнэ: Энэ их чухал юм орж ирж байгаа юм. Тэгээд Тэмүүлэн гишүүндээ баярлаж байна. Малчны тухай хууль уул нь их зөв хууль, тэгээд ингээд хэрэгжилт дээр алдаа гараад, энэ чинь яг ний нуугүй хэлэхэд 2024 оны сонгуульд маш том нөлөө үзүүлсэн хууль шүү дээ. Яг ний нуугүй хэлэхэд орон нутгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд энийг маш сайн анзаарсан байх. Тэгээд бид энэ яагаад болохгүй, яагаад ингээд хөдөө орон нутагт байгаа гэдгээр нь малчдаа нүд үзүүлээд байдаг юм уу, эсвэл Малчны тухай хуулиа батлагдах процесс дээр НДШ нөхөн төлбөртэй холбоотой асуудал нь болно, болно гэж баталчхаад, сонгууль нь өнгөрсний дараагаар болохгүй, болохгүй гээд мөнгийг нь өгдөггүй, тавьдаггүй, журмыг нь ЗГ дээр баталж өгдөггүй ийм л процесс үүсчхээд байгаа байхгүй юу. Гэх мэтчилнээс авхуулаад ингээд олон асуудлууд байгаа. Тэгээд би энэ ерөнхий

хяналтын сонсголыг дэмжиж байгаа. Энэ заавал хийгдэх ёстой ажил. Маш олон малчдын асуудал энэ дотор хөндөгдөж байгаа нэг.

Нөгөөдөх нь бид малчдыг зөвхөн мал хариулдаг гэж ойлгоод байх шиг байна. Үгүй шүү дээ энэ малчид гэдэг хүмүүс чинь тухайн газар орон нутагтаа эзэн болдог, байгалиа хамгаалдаг, ой хээрийн түймэр, бусад гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлж байдаг. Дээрээс нь Монгол Улсын хүнсний хэрэгцээг хангаж байдаг, тусгаар тогтнолын баталгаа. Энэ чинь хаана энэ газар, орон нутагт малчдаас өөр хэн байгаа юм бэ? Тэгээд махаа өгье гэхээр ченжүүд нь аваад үнэд оруулаад алга болдог. Сүүгээ, цагаан идээгээ гээд тэгэхээр худалдан авдаг хүн нь байдаггүй, тээвэр нь байдаггүй, үйлдвэрлэл нь байдаггүй, боловсруулах цех нь байдаггүй. Тэгээд бид яг ний нуугүй хэлэхэд малчдаа ингэж хулхидаж болохгүй. Сонгуулийн өмнө ёстой бүсчилсэн хөгжлийн хүрээнд алаад өгнө, талаад өгнө, та нарын амьдралыг сайхан болгоод өгнө. Малчны хуулийг чинь манай Тэмүүлэн гишүүн ингээд гаргаад ирсэн, баталсан. Одоо бид бараг л 3 сумын дунд нэг боловсруулах үйлдвэр байгуулна. Сүү, цагаан идээ чинь үнэтэй болно. Махыг чинь бид хажууд чинь бараг агуулахыг нь барьж өгч байгаа та нар энэ махаа үнэд оруулж зардаг болгоно, арьс ширийг чинь хил давуулаад алаад өгнө л гээд байсан үнэд оруулна гээд. Тэгээд өнөөдөр 2 жил өнгөрч байна сонгууль дууссанаас хойш. Хэн дээр гацаад байгаа юм, яагаад ийм асуудал үүсээд байгаа юм. Тэгээд энэ эзэн холбогдогч нарыг нь бид яг ний нуугүй хэлэхэд асуудалтай бол тогтоох хэрэгтэй. Ямар албан тушаалтан ингээд дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргээд байдаг юм. Тэгээд энийг би дэмжиж байгаа. Тэмүүлэн гишүүнийг санаачилж оруулж ирж байгаад баяртай байна. Тэр ч утгаараа би дэмжиж гарын үсэг зурсан. Баярлалаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа. Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.313 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1.1 дэх заалт, 120.2 дахь хэсэг, 121 дүгээр зүйлийн 121.1, 121.13 дахь хэсэг, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 29.2.2 дахь заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын БОХХАА-н байнгын хорооноос тогтоох нь:

1.Ерөнхий хяналтын сонсголыг Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдвээр 2026 оны 6 дугаар сарын 23, 24-ний өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэмлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсгол даргалагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг сонгосугай.

3.Ерөнхий хяналтын сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар Л.Өлзийсайханд даалгасугай гэсэн байна. БОХХАА-н байнгын хороо гээд. Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, даргалагчийг сонгох тухай

Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдэг санал хураалт. Дараагийн асуудал нэмэх нь. Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асууя гэж байна. Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Тэмүүлэн гишүүний санаачилж байгаа сонсголыг дэмжиж байгаа. Малчны тухай хуулиас гадна ер нь МАА-н салбарт малчдын эрх зүйн байдлыг зохицуулахтай холбогдолтой 7, 8 төрлийн хуулиуд байгаа. Тэгэхээр яах вэ цар хүрээг нь зөвхөн Малчны тухай хуулиар гэхгүйгээр жоохон өргөн хүрээнд бас нэгэнтээ сонсгол хийж байгаа юм чинь хийвэл ямар байх вэ гэдэг дээр та хэд маань судалсан, ярилцсан зүйлүүд байгаа юу гэдгийг дахиад нэг тодруулчихъя. Тэгээд ер нь жоохон өргөжүүлээд 7, 8 хуулиудын асуудлыг оруулчихаар юу болох уу, эсхүл зөвхөн Малчны тухай хуулиар явах нь зөв үү гэдэг дээр ямар бодолтой байна вэ гэдгийг тодруулчихъя.

Б.Бейсен: Асуулт асуусан уу, үг хэлсэн үү, асуулт асуусан уу? Тэмүүлэн гишүүн хариулах юм байна.

Г.Тэмүүлэн: Малчны тухай хуулийг 24 оны 6 сард анх санаачлаад ингээд батлуулж байсан УИХ-аар. Тэгээд үндсэндээ Үндсэн хуульд зааснаараа төрийн бодлогыг тодорхойлох, үндсэндээ энэ хууль тогтоолыг санаачлах үндсэн эрх төрийн эрх барих дээд байгууллага буюу Улсын Их Хурлын өөрийнх нь бүрэн эрх байгаад байгаа. Үндсэн хуульд зааснаараа ЗГ угаасаа энэ хууль тогтоомжуудын биелэлтийг хангах, эргээд биелүүлэх энэ ажлыг зохион байгуулах үндсэн үүрэг ЗГ дээр байгаа. Тэгэхээр Үндсэн хуулийнхаа хүрээнд л яг шаардлага тавьж, энэ хуулиудыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг нь хяналт тавих эрхээ л УИХ хэрэгжүүлэе гэсэн үндсэн дээр энэ сонсголыг зохион байгуулж байгаа.

Гол үндсэн яах вэ би өөрөө анх нэр бүхий гишүүдтэй 26 он, 24 онд санаачилж энэ хуулийг боловсруулж, УИХ-аар батлуулахдаа хэрэгжилтийг хяналт тавих эрхээ хэрэгжүүлнэ гэдэг бас үүргээ хүлээж байсан. Тэгээд энэ хүрээндээ яг өөрийнхөө санаачилсан энэ хууль дээрээ л сонсголыг оруулж ирсэн. Мэдээж юу гэдэг юм Байнгын хороо болоод, гишүүд энэ асуудлыг хэлэлцээд, холбогдох хууль тогтоомжийнх нь хүрээнд, цаашид өргөн хүрээнд бусад хуулиудын хүрээнд зохион байгуулах эсэх эрх нь мэдээж нээлттэй. Гэхдээ онцгойлоод яах вэ хэрэгжилт хамгийн хангалтгүй байгаа хууль гэвэл бараг үндсэндээ энэ байгаа байх. Магадгүй юу гэдэг юм Малын эрүүл мэндийн тухай хууль, Малын удмын сан болоод генетик нөөц болоод Хоршооны тухай хууль ч гэдэг юм уу эдгээр хуулиудтай харьцуулахад хэрэгжилт хамгийн доогуур түвшинд яваа хууль байж магадгүй гэдэг түвшин байгаа.

Цар хүрээнийх нь хүрээнд авч үзвэл энэ хууль маань үндсэндээ энэ МАА-н үйлдвэрлэлийг илүү тогтвортой, зах зээлд илүү өрсөлдөх чадвартай салбар болгон хөгжүүлэхэд чиглэсэн, эргээд тухайн малчин хүнийх нь эрх ашгийг нь ч гаргаж ирсэн, тухайн мал дээр гарахаас авхуулаад эргээд тэтгэвэрт гарах хүртэлх тэр хүний эрүүл мэнд, нийгмийн баталгаа, ажлын байр, мөн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах болон эдийн засгийн баталгаа, санхүүгийн тэр орлого, амьжиргаа орлогыг нь дээшлүүлэх гээд бүхий л энэ асуудлыг анх удаагаа үндсэндээ энэ иж бүрэн тодорхойлоод, ингээд олон зохицуулалтыг бий болгоод, эрх зүйн талаас хамгийн анхны том ахиц дэвшлийг бий болгосон ийм л үндсэндээ ач холбогдолтой хууль байгаад байгаа юм.

Гэтэл өнөөдөр үндсэндээ энэ асуудлууд маань хууль өөрөө хэрэгжилтгүй байгаагаас хамаараад энэ ХАА-н салбарт болоод, хөдөө орон нутагт байгаа суурь асуудлууд маань шийдэгдээгүй хэвээр байгаад байгаа юм. Тэгээд л бүгдээрээ мэдэж байгаа түүхий эд нь өөрөө үнэ цэнгүй байдаг, орлого нь тогтворгүй байдаг, эргээд юу гэдэг юм төрийн бодлогын гажуудлын үндсэн дээрээс үндсэндээ юу гэдэг юм залуу малчид өөрсдөө цөөрч байгаа, хот орон нутаг рүү, төв суурин газар луу шилжиж байгаа ч гэдэг юм уу, эргээд хөдөлмөрийн үнэлэмж нь муу байгаагаас хамааралтай энэ үр дагаврууд хэвээрээ байгаад байна. Тэгэхээр бид энэ асуудлыг томоор нь цогцоор нь энэ суурь анхдагч хуулийг эргээд нэг харахад үндсэндээ ХАА-тай холбоотой бүх асуудлууд хөндөгдөөд явах, гарц шийдлийг, гаргалгааг нь хараад явах ийм боломж, бололцоо бүрдэх байх л гэсэн ийм үндсэн дээр ингэж оруулж ирсэн.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Малчны тухай хуулиараа хэлэлцэх нь зөв. Тэгэхдээ Мөнх холбоо гээд жишээ нь гэвэл тэгээд л байгуулсан байгаа. Дахиад ингээд ер нь яах вэ давхардалтай малчны яг эрх зүйн байдалтай холбогдолтой асуудал нэгэнтээ сонсголыг илүү үр бүтээлтэй явуулах тодорхой асуудлуудыг нь ингээд бүрэн харах гэдэг агуулгаар нь Ажлын хэсэг дээр боломжтой бол энэ талд, хүрээтэй холбогдолтой асуудлыг яриад, энэ хүрээндээ байх уу, эсхүл жоохон өргөжүүлэх үү гэдгийг сонгож болохоор тийм байдлаар баталж өгч болох уу? Тэгвэл 7, 8 л хууль байгаа юм. Яг малчид руу чиглэсэн тодорхой асуудлыг нь зохицуулж байгаа. Тэгэхээр тэндээсээ аль, аль хүрээндээ байх вэ гэдгийг нь ажлын хэсэг ярилцаад явчихвал энэ давхардалт руу тодорхой асуудлуудыг ярих боломж нь байх уу гэдэг дээр ийм санал зүгээр байгаа юм. Тэгээд энийг ажлын хэсгээрээ ярих боломж байвал олгоод өгөөч.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, асуулт, хариулт авч дууслаа. Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдгээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Ажлын хэсэг дээр дахиж санал хураана шүү дээ. Тэмүүлэн гишүүд санаачилсан шүү дээ болох юм уу? Малчны тухай хуульд чинь тэр дотор нь багтаад байгаа юм биш үү? Тэмүүлэн гишүүний юугаар хүсэлтээр нь зүгээр Малчны тухай хууль гэсэн байгаа юм даа. Тэмүүлэн гишүүн. Тэмүүлэн гишүүний микрофон өгье.

Г.Тэмүүлэн: Мэдээж татгалзах зүйл байхгүй. Угаасаа МАА-тай холбоотой хуулиудыг бүгдийг нь аваад, ингээд хяналт тавиад, сонсгол зохион байгуулах эрх нь нээлттэй. Тэгэхээр би зүгээр анхнаасаа яах вэ хүсэлт өгсөн нь зөвхөн Малчны тухай хуулийн хэрэгжилтээр гээд өгчихсөн юм. Тэгэхдээ мэдээж ажлын хэсэг энэ дээр гараад, эргээд тухайн тэр сэдэв болоод цар хүрээг нь тодорхойлоод, ингээд хэлэлцэх асуудлуудаа ажлын хэсэг дотроо батлаад явна гэж харж байгаа. Тэгэхээр энэ дотроо ерөнхий энэ тогтоолын төсөл дээр Малчдын тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх гэж орж ирсэн байгаад байгаа. Тэгэхээр би энэ дотроо Мөнх холбооны тухай хууль ч гэдэг юм уу тэрийг хамруулаад оруулаад явах эрх би нээлттэй байж болох байх гэж хараад байгаа юм. Ерөнхий зорилго өөрөө нэг учраас. Тэгэхээр төлөвлөгөөндөө оруулаад явчхаж болох байх энийг.

Б.Бейсен: Агуулгын хувьд ерөнхийдөө төлөвлөгөөнд ороод явчих боломж байгаа юм байна шүү дээ тийм ээ? Санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт.

55,6 хувиар дэмжигдлээ. Ганхүлэг гишүүнийг дэмжсэнээр авъя. Дараагийн асуудал, энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

17.28 цаг

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Дараагийн асуудалд оръё. Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсэг байгуулах тухай. Байнгын хорооны тогтоолоор сая байгуулсан Ерөнхий хяналтын сонсголын тов болон сонсгол даргалагчийг томилсон. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3-д Байнгын хороо сонсгол зохион байгуулах ажлын хэсэг байгуулж болно гэж заасны дагуу Ажлын хэсэг байгуулах тогтоолын төслийг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн байгаа. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Замира гишүүн, Мөнхбаясгалан гишүүн саяын саналаа хэлэх юм байна. Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Энэ Ажлын хэсэг байгуулах тухай, энэ мөн үү? Малчны тухай хуулийн хяналтын сонсгол хийх энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа. Говийн бүсээс сонгогдсон, хөдөөгөөс сонгогдсон гишүүний хувиар маш олон асуудал байгаа. Тэгэхээр энэ ажлын хэсэгт орох саналаа өгч байна.

Б.Бейсен: Замира гишүүн.

С.Замира: Баярлалаа. Их Хурлын гишүүн Тэмүүлэнгийн энэ санаачилж байгаа Малчны тухай хуулийн хэрэгжилтэд ерөнхий хяналт сонсгол явуулах тухай энэ ажлын хэсэгт орж ажиллая. Яагаад гэвэл малчдын асуудал бид маш гол асуудал болж байгаа учраас энэ ажлын хэсэгт орох саналтай байна.

Б.Бейсен: Одоогоор даргатай нийтдээ 9 гишүүн байгаа. Бид сонсгол даргалагчийг томилсон Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн томилогдсон байгаа. Сонсголд даргалагч зөвшөөрвөл энэ 2 гишүүнийг нэмж оруулъя. Үгүй ээ, таныг томилсон шүү дээ бид. Шууд асуухгүй бол. Тогтоолын төслийг сая баталсан. Бат-Эрдэнэ дарга зөвшөөрч байгаа юм байна, энэ 2 гишүүнийг нэмж, ажлын хэсэг 11 гишүүний бүрэлдэхүүнтэй баталъя. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг бүхий байгууллагууд, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга, гишүүд Д.Батбаяр Улсын Их Хурлын гишүүн, Б.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн, Г.Ганбаатар Улсын Их Хурлын гишүүн, М.Ганхүлэг Улсын

Их Хурлын гишүүн, У.Отгонбаяр Улсын Их Хурлын гишүүн, Р.Сэддорж Улсын Их Хурлын гишүүн, Ц.Туваан Улсын Их Хурлын гишүүн, Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын гишүүн, Л.Мөнхбаясгалан Улсын Их Хурлын гишүүн, С.Замира Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ зөвшөөрсүгэй.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга /Б.Бейсен/-д даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдгээр санал хураалт явуулна, гишүүд санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт. Энэ тогтоолын төсөл батлах Ажлын хэсэг батлах тогтоолын төсөл 55,6 хувиар дэмжигдлээ. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

17.23 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА